

орчин·21



2017 01(27)

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо



АЙМАГ ОРОН НУТГИЙН НИЙТИЙН
АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
ШИНЭР ТОМИЛОГДСОН ДАРГА,
УДИРДЛАГУУД БХБ-ЫН САЙД **Г.МӨНХБАЯР**
ОСНААБХЗГ-ЫН ДАРГА **О.ЛХАГВАЦЭДЭН**
МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ДЭД САЙД Ш.ЛХАМСҮРЭН :

**БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА**





ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО

1 ядуурлыг устах	2 өвслөлийн зогсох	3 зруул мэндийг дэмжих	4 чанартай боловсролыг дэмжих	5 жендерийн эрх тэгш байдлыг хангах
6 баталгаат унны ус аринүү цэврүүн байгууламжаар хангах	7 сэргээгдэх зэрийн хүчингээ нэвтрүүлэх	8 зийн засгийн освилт баталгаат ажлын байрыг бий болгох	9 инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх	10 тэгш бус байдлыг бүүрүүлах
11 зэлтэй хот, ирээдүүн оролцог дэмжих	12 хариуцлагатай хэрэлдээг дэмжих	13 үүр амьсгалын өвөрчлөлийн үр нөвлөг багастах	14 далай тэнгисийн нөөцийг хамгаалах	15 хуурай газрын экосистемийг хамгаалах
16 энх тайван, шударга ёсыг цогцлоох	17 хөгжлийн төлөөх туушаалыг бэхжүүлях	 SUSTAINABLE DEVELOPMENT GOALS		

ОРЧИН 21

МОНГОЛЫН НИЙТИЙН
АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХОЛБОО



2-61 ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Засгийн газрын тогтоолууд



62-82 МЭДЭЭЛЭЛ

“Бохир ус цэвэрлэх байгууламжийн технологийн шийдэл, цаашдын чиг хандлага” хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмж



83-86 ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ

Дэд бүтэц - Ухаалаг шийдэл



87 ЯРИЛЦЛАГА

НҮБ-н Хүүхдийн сангийн Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн мэргэжилтэн Н.Батнасан



88-90 САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН

МУ-ын Үйлчилгээний гавьяат ажилтан С.Сүхээ

ОРЧИН 21

ЭРХЛЭГЧ:

Б.Пүрэвжав

/Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Техникийн ухааны магистр, МУ-ын зөвлөх инженер/

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

С.Дагвадорж

/Таван Өндөр ХХК-ийн захирал/

МЕНЕЖЕР:

Б.Алтантуул

ДИЗАЙНЕР:

Н.Наранболд

ISSN 0115-1564(2017-01(27)) Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо

АЙМАГ ОРОН НУТГИЙН НИЙТИЙН АЖ АХУЙН БАЙГУУЛАГАУУДЫН ШИНЭР ТОМИЛОГДСОН ДАРТА. УДИРДЛАГАУУД БХБ-ЫН САЙД Г.МӨНХБАЯР ОСНААБХЗГЫН ДАРГА О.ЛХАГВАЦЭДЭН МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ДЭД САЙД ШЛХАМСУРЭН :
БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

УТАС: 70101779 MNAAUH@YAHOO.COM



МЭНДЧИЛГЭЭ



Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт ажиллаж байсан үе үеийн ахмадууд, одоо сэтгэл зүтгэл гарган хөдөлмөрлөж буй хамт олон, тэдний гэр бүл, үр хүүхэд түмэн олондоо уламжлал ёсоор “Орчин 21” сэтгүүлээр дамжуулан “Алтан унжлагат” гал тахиа жилдээ эрүүл энх, амар амгалан, аз жаргалтай байх өрөөл өргөн мэндчилж байна.

Улиран одож буй Бичин жил хур бороо элбэгтэй, ногоо цагаа дэлгэрсэн сайхан жил байлаа. УИХ-ын болон Орон нутгийн хурлын төлөөлөлөө сонгох хариуцлагатай жил болж Монголчууд сонголтоо хийллээ.

Сонгуулийн үр дүнд манай салбарын хот, орон нутгийн ихэнх байгууллагуудын удирдлага шинээр томилогдон ажиллаж байна.

Монголчууд бид хийморьлог, амны хишиг ихтэй, ёс уламжлалаа дээдэлсэн билигдэлтэй ард түмэн билээ.

Тиймээс аливаа зүйлийн сайн талыг түрүүлэн харж, сайн сайхнаар бодож сэтгэн, ямагт өөдрөг бодлоор өөрийгөө болон өрөөл бусдыг урамшуулан дэмжиж, өөр хоорондоо эвтэй байж, зөв үйлийн төлөө зүтгэвэл айл гэрийн амьдрал, байгууллага хамт олны ажил бүтээл хийгээд улс орны хөгжил, өнгө төрх тэр хэрээрээ л дэвжин дээшлэх нь дамжиггүй.

Гал тахиа жилд улс орны хувьд эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй байгаа боловч олон улсын валютын сан болон бусад хандивлагч орны санхүүгийн дэмжлэгтэйгээр хүндрэлээс гарч чадна гэсэн итгэлтэй байна.

Салбарын нийт хамт олны хувьд Барилга хот байгуулалтын яам, агентлаг, Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд үнэ тарифын асуудлаа шийдвэрлүүлэх, санхүүгийн боломж чадавхia сайжруулах чиглэлд тодорхой үр дүнд хүрэх боломж бүрдсэн гэж үзэж байна.

Угтан золгож буй Гал тахиа жилд та бидний ажил үйлс бүтээмжтэй, өлзий буян дэлгэрч өлмий бат орших болтугай.

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний
холбоо МТТБ-н Гүйцэтгэх захирал

Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан
Техникийн ухааны мастер, МУ-ын зөвлөх инженер

Б.ПУРЭВЖАВ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 121

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсвийн төсөл, гадаад зээл, тусламжийн болон төр, хувийн хэвшлийн туншлэлийн бодлогод тус тус тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Үндэсний хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярсайхан нарт даалгасугай.

3. Төлөвлөгөөнд тусгасан томоохон төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэлийг 2017 онд багтаан эцэслэн боловсруулж, 2018 оноос хэрэгжүүлж эхлэх бэлтгэлийг бүрэн хангаж ажиллахыг Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Үндэсний хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярсайхан нарт тус тус даалгасугай.

4. Эрхлэх асуудлын хүрээнд харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, үнэлгээ хийж, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Монгол Улсын сайд,

Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга

Ж.МӨНХБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 45

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт,
Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн
Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хавсралт-аар баталсугай.

2.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

1/Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэг-жүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулж байх;

2/Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүл-сэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх.

3.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг холбогдох бусад байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**М.ЭНХБОЛД**



Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Улсын Их Хурлын ээлжит 7 дахь удаагийн сонгуулийн үр дунд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд сонгогчдын санал, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд үндэслэн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Монгол Улсад бий болсон эдийн засаг, санхүүгийн хүнд нөхцөлд Засгийн газрын гол зорилт нь улс орныхоо эдийн засгийг богино хугацаанд сэргээж, есөлтийг бий болгон нийгмийн салбаруудыг дэмжиж, иргэдийнхээ аж амьдралыг эрс сайжруулахад оршино. Мөн төрийн албыг чадавхжуулах, бүх шатанд мэргэшсэн албан хаагчидтай байж, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй үзүүлэх, нийгмийн итгэлцлийг бэхжүүлэн, улс үндэстний аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэсэн тодорхой зорилтуудыг дэвшүүллээ.

НЭГ.ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО

Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцилийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.

1.1. Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах, тогтвортой хөтөлбөр боловсруулна.

1.2. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

1.3. Төсвийн нэгдмэл байдлыг ханган, төсвөөс гадуурх санхүүжилтийг зогсоож, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.4. Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна.

1.5. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, ард иргэдэд нээлттэй, ил тод болгоно.

1.6. Ард иргэд, аж ахуйн нэгж, улс орноо өрийн дарамтаас гаргаж, иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжин орлогыг нэмэгдүүлнэ.

1.7. Төрөөс захиалгаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсөө авч чадахгүй байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг барагдуулна.

1.8. Өр зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, үндсэн төлбөрийн хугацааг хойшшуулах чиглэлээр яриа хэлэлцээ хийж, улсын төсөвт тулгарч буй өрийн дарамтыг үе шаттайгаар бууруулна.

1.9. “Үнэ тогтвортуюулах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн ашиглалтад үнэлэлт, дүгнэлт өгч, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

1.10. Хөгжлийн банкны бонд, зээлийн зарцуулалтыг дүгнэж, төсөл, хөтөлбөрт үнэлгээ хийж, зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зээлийг буцаан төлүүлнэ.

1.11. Шинэ төрлийн татвар бий болгохгүй ба үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд тодорхой салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 1.5 тэрбум төгрөгөөс бага жилийн орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулна.

1.12. Аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татварыг орлогын түвшингээс хамаарсан шатлалтай болгоно.ах боломж олгоно.



1.13.Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

1.14.Үндэсний хөрөнгө оруулагчдыг бүхий л талаар дэмжиж, эхний хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэл орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

1.15.Эрх бүхий байгууллагуудаас үндэсний аж ахуйн нэгжүүдэд тавигдсан татварын актын хүү, торгууль, алданги, үндсэн татварын нөхөн төлбөр төлөх хугацааг сунгах, хаалгасан дансыг нь нээх зэргээр бизнес эрхлэгчдээ дэмжинэ.

1.16.Эдийн засгийн хүндрэлээс улбаалан ажил, орлого нь хумигдан, зээлээ төлж чадахгүйд хүрч, “Найдваргүй зээлдэгчдийн жагсаалт”-д бүртгэгдсэн аж ахуй нэгж, иргэдэд зээлээ эргэн төлж, зээлийн түүхээ сайжруулах боломж олгоно.

1.17.5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.

1.18.Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулна.

1.19.Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана.

1.20.Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эмзэг байдлыг бууруулах, эрсдэлийг багасгах чиглэлээр олон улсын болон бус нутгийн банк, санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

1.21.Түншлэгч улс орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай зөвшилцэх уулзалтуудыг сэргээн зохион байгуулна.

1.22.Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болон Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээнэ.

1.23.“Үндэсний үйлдвэрлэл” хөтөлбөрийн хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

1.24.“Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна.

ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна.

2.1.Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2.Монгол Улсад үйлдвэрлэсэн уул уурхайгаас бусад салбарын бүтээгдэхүүний 50-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа аж ахуйн нэгжийг татварын бодлогоор дэмжинэ.

2.3.“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааг үнэ цэнэтэй болгоно.

2.4.Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлнэ.

2.5.Томоохон төслийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хугацааг уртасгаж, хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6.Иргэндээ зэлтэй, эдийн засагтаа үр өгөөжтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ.

2.7.Стандартчилал, хэмжил зүйн талаархи хууль тогтоомжийг олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн шинэчилж, “Үндэсний чанарын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

2.8.Бараа бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдаан дахь техникийн саад тогторыг багасгахад Стандартчилал, тохирлын үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх, хэрэглэх, ашиглах механизмыг оновчтой болгоно.

2.9.Үйлдвэрлэлд ашиглагддаг уур, ус, дулаан, цахилгааны тарифыг тогтвортой байлгаж, аажмаар бууруулах бодлого баримтална.



2.10.Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

2.11.Чөлөөт бусуудийн үйл ажиллагаагаа эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.

2.12.Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна.

2.13.Дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжинэ.

2.14.Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, эсхүл нэг цэгт үзүүлж, чирэгдлийг багасгана.

2.15.“Итгэлийн зээл”-ийг олгож, жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

2.16.Хөдөө орон нутаг, алслагдсан бус нутагт бизнес эрхлэлтийг дэмжих “Бүсийн хөнгөлөлт”-ийн бодлого хэрэгжүүлнэ.

2.17.Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.

Дэд бүтцийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.80.Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.81.Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.82.Норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн

шинэчилж, олон улсын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх орчинг бүрдүүлнэ.

2.83.Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бус нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоо чиглэлээр үе шаттайгаар боловсруулна.

2.84.Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

2.85.Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинэчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.

2.86.Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.87.Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

2.88.Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн ногоон байгууламжийг З дахин нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.89.Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.90.Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ.

2.91.Барилга байгууламжийн өөрийн өртгийг бууруулах, барилгын үйлдвэрлэлийн хугацааг уртасгах, барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулаад чиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2.92.Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтэд тусгах, ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ.



2.93. Нийтийн аж ахуйн талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.

2.94. Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын үнд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

2.95. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хот болон бусад томоохон хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийг үе шаттай шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.96. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.97. Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, амралт, зугаалгын бүс, номын санд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2.98. Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Туул, Сэлбэ, Дунд голын урсацыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ.

2.99. Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорхи болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ.

2.100. Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээг барьж байгуулах ажлыг дуусгана.

Эрчим хүчиний салбарын чиглэлээр:

Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчиний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцөлийг бүрдүүлнэ.

2.101. Улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн үндэс болсон суурин салбарын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашиглалтад байгаа цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх, шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ. /Чойбалсангийн ДЦС, Улаанбаатарын Гуравдугаар ДЦС/

2.102. Монгол Улсын эрчим хүчиний хангамжийн найдвартай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах шинэ эх үүсвэрийг барих, Өмнөд говийн уул уурхайн цахилгааны хэрэглээг хангах Тавантолгойн уурхайн нүүрсээр ажиллах цахилгаан станцыг барих асуудлуудыг шийдвэрлэнэ.

2.103. Шивээ-Овоо, Тэвшийн говь болон бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ.

2.104. Сэргээгдэх эрчим хүчиний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, Эгийн голын усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлнэ.

2.105. Бүс нутгийн эрчим хүчиний систем, хүнд үйлдвэрүүд, том хэрэглэгчид, эрчим хүчиний эх үүсвэрүүдийг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, эрчим хүчиний нэгдсэн систем байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

2.106. Аймгийн төвүүд болон томоохон хот, суурин газарт дулааны станц, шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх, эрчим хүчээр бүрэн хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.107. Сумын төвүүдийг төвлөрсөн цахилгаан системд бүрэн холбож дуусган сэргээгдэх эрчим хүч болон цэвэр технологид суурилсан төвлөрсөн инженерийн байгууламж буюу дулаан хангамж, цэвэр бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.108. Эрчим хүчиний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, инновацийн түвшний шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 71

“ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨР” БАТЛАХ ТУХАЙ

Эдийн засгийг сэргээх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Тэргүүн ээлжинд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эдийн засгийг сэргээх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус үүрэг болгосугай:

1/“Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;

2/энэ тогтоолын хавсралтад заасан банк, санхүү, төсөв, бодит салбарын үйл ажиллагааг дэмжих, тогтвортжуулахад шаардагдах хөрөнгийг гадаад, дотоод эх үүсвэрээс нэн даруй босгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/эдийн засгийг сэргээхтэй холбоотой тэргүүн ээлжинд боловсруулж батлуулах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх.

3.Хөтөлберийн хэрэгжилтийн явц, үр дүнг тооцож, хугацаандaa хэрэгжээгүй заалт бүрийг хариуцах албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэж, хөтөлбериийн явцыг хагас жил тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын холбогдох байн-гын хороодод даалгасугай.

5.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2014 оны “Эдийн засгийн идэвхижлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 34 дүгээр тогтоол, 2015 оны “Эдийн засгийн хүндрэлзээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоолыг 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО					
<p>Тэргүүлэх зорилт №2.4. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.</p>					
2.76. Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Орон сууцны ипотекийн зээлийн хэрэгжилт, өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, ипотекийн зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлогын хүрээнд зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах	2016-2017	-	-
	2	Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх	2016-2020	Ирээдүйн тэтгэврийн нөөц сан, бусад эх үүсвэр	960,000.0
2.77. Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, "Хямд өртөтэй орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1	"Орон сууц" үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2016-2020	Улсын төсөв	20.0
	2	"Ногоон хувийн орон сууц" загвар төслийг үе шаттай эхилүүлэх	2017-2020	Улсын төсөв	450.0
	3	Аймаг бүрт "1000 айлын орон сууц" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2016-2020	Улсын төсөв	1,000.0
	4	Нийслэлд 1000 айлын түр орон сууцыг барьж ашиглалтад оруулах	2017-2020	Гадаад эх үүсвэр	61,200.0
2.78. Норм, нормативын баримт бичгийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, олон улсын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх орчинг бүрдүүлнэ.	1	Барилга байгууламжийн норм, нормативын ерөнхий баримт бичгийн ерөнхий тогтолцоог шинэчлэн боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангуулах	2016-2018	Улсын төсөв, Барилга, байгууламжийн норм, нормативын сан	1,200.0
	2	Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, мөрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	2016-2020	Барилга, байгууламжийн норм, нормативын сан	3,000.0
	3	Шингэрүүлсэн хийн түлш, сэргээгдэх эрчим хүчиний нөөцийг ашиглах болон ногоон барилгын чиглэлээр төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай норм, дүрэм, стандартыг боловсруулах, батлах	2017-2020	Гадаад эх үүсвэр	6,000.0



Хүрэх тувшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)								Хэрэгжүүлэх байгууллага					
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч			
Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв						
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО													
Тэргүүлэх зорилт №2.4. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжих, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.													
Орон сууцны ипотекийн зээлийн хэрэгжилт, өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулах		Хэрэгжилтийг хангуулж ажиллах		Хэрэгжилтийг хангуулж ажиллах		Хэрэгжилтийг хангуулж ажиллах		БХБЯ	СЯ, ХНХЯ	Монголбанк, МИК			
Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлд 4000 иргэн нэмж хамрагдах	240,000.0	Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлд 4000 иргэн нэмж хамрагдах	240,000.0	Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлд 4000 иргэн нэмж хамрагдах	240,000.0	Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлд 4000 иргэн нэмж хамрагдах	240,000.0	СЯ, ХНХЯ	Монголбанк, МИК	Арилжааны банкууд			
Холбогдох судалгааг хийх	8.0	Хөтөлбөрийн төслийг боловсруулж, батлуулах	12.0	Хөтөлбөрийг хэрэгжилтийг зохион байгуулах, эхлүүлэх	-	Хөтөлбөрийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх	-	БХБЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд	-			
Төслийн холбогдох судалгааг хийж, заввар төслийн зургийн даалгаврыг батлах	150.0	Төслийн зураг төслийг боловсруулах	150.0	Заввар төслийг хэрэгжүүлж эхлэх	150.0	Заввар төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	-	БХБЯ	-	ААН-үүд			
6 аймарт 1000 айлын орон сууц барих ажлыг зохион байгуулах	300.0	2 аймарт 1000 айлын орон сууц барих ажлыг зохион байгуулах	300.0	2 аймарт 1000 айлын орон сууц барих ажлыг зохион байгуулах	200.0	2 аймарт 1000 айлын орон сууц барих ажлыг зохион байгуулах	200.0	БХБЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд	МХЕГ, ААН-үүд			
Хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх, хороолын хэсэгчилсэн ерөнхий төвлөвлөгөө, нарийвчилсан зураг төслийг боловсруулах	1,200.0	Нийслэлд 1000 айлын түр орон сууц барих ажлыг эхлүүлэх	30,000.0	Нийслэлд 1000 айлын түр орон сууц барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	30,000.0	Нийслэлд 1000 айлын түр орон сууцны барилга ашиглалтад оруулах	-	БХБЯ	НЭДТГ	ААН-үүд			
Барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоог шинжилэн батлуулж, хэрэгжүүлэх нөхцлийг бурдуулж	700.0	Барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоог хэрэгжүүлэх	500.0	Барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоог хэрэгжүүлэх	-	Барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоог хэрэгжүүлэх	-	БХБЯ	БХТ	ААН-үүд			
Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг олон улсын жишигт нийцэх	750.0	Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг олон улсын жишигт нийцэх	750.0	Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг олон улсын жишигт нийцэх	750.0	Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг олон улсын жишигт нийцэх	750.0	БХБЯ	СХЭГ, БХТ	ААН-үүд			
Холбогдох норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах	1,500.0	Холбогдох норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах	1,500.0	Холбогдох норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах	1,500.0	Холбогдох норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах	1,500.0	БХБЯ	Холбогдох яамд, агентлаглагууд	МХЕГ, ААН-үүд			



ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
2.79. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бус нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоо чиглэлээр үе шаттайгаар боловсруулна.	1	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах ажлын хүрээнд Хот байгуулалт, эрдэм шинжилгээний зураг төслийн институтийн байгуулж, сурь судалгааны ажлыг гүйцэтгэх	2016-2019	Улсын төсөв	2,000.0
	2	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулж, батлуулах	2016-2019	Улсын төсөв	5,600.0
	3	"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлан, хэрэгжилтийг зохион байгуулах	2019-2020	Улсын төсөв	4,200.0
	4	"Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого"-ыг боловсруулах	2018-2020	Улсын төсөв	1,000.0
2.80. Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчилэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	1	Төрөөс газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах	2016-2018	-	-
	2	Газрын тухай, Газрын кадастрын тухай, Газрын үнэлгээ, төлберийн тухай, Геодези, зураг зүйн тухай хуулиудын эрх зүйн шинэлгэлийг хийх	2016-2019	-	-
	3	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2016-2018	-	-
	4	Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан Газар чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2016-2018	-	-
	5	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2016-2018	-	-
	6	Улсын тусгай хэрэгцээний газарт хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, холбогдох дүрэм, журам, норм, стандартыг боловсронгуй болгох	2016-2018	Барилга, байгууламжийн норм, нормативын сан	10.0
	7	Газрыг зохистой ашиглах, хамгаалах, нехэн сэргээх тогтолцоог бүрдүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах	2016-2020	Улсын төсөв	1,000.0



Хүрэх түвшин, үр дун (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)							Хэрэгжүүлэх байгууллага			
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Хүрэх түвшин, үр дунгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дунгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дунгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дунгийн үзүүлэлт	Төсөв			
Монгол Улсын хүн амын нутагшатилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ХБЭШЗТИнститутийг байгуулж, төслийн холбогдох судалгааны ажлыг эхлүүлэх	1,000.0	Судалгааны ажлыг гүйцэтгэх	1,000.0	Судалгааны ажлыг гүйцэтгэх	-	-	-	БХБЯ	ҮХГ, СЯ, холбогдох яамд, агентлагууд	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
Монгол Улсын хүн амын нутагшатилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн зургийн даалгаврыг баттуулах	2,600.0	Төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах	2,000.0	Төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	1,000.0	-	-	БХБЯ	ҮХГ, СЯ, холбогдох яамд, агентлагууд	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
-	-	-	-	Төслийг хэрэгжүүлэх ўйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баттуулах	-	Хэрэгжилтийг хангаж ажиллах	4,200.0	БХБЯ	ҮХГ, СЯ, холбогдох яамд, агентлагууд	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
-	-	"Бүсчилсэн хөгжлийн бодлого" боловсруулахад шаардлагатай нөхцөл байдлын дүн шинжилгээ, нэлэөллийн урьдчилсан үнэлгээ хийх	1,000.0	"Бүсчилсэн хөгжлийн бодлого"-ын хувигдبار, схем, зурагталь боловсруулах	-	"Бүсчилсэн хөгжлийн бодлого"-ын баримт бичгийг боловсруулах	-	ҮХГ	Холбогдох яамд, агентлагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд	ЗШБ-үүд
Бодлогын баримт бичгийг төслийг боловсруулах	-	Бодлогын баримт бичгийг баттуулах	-	Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх	-	Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх	-	БХБЯ	ГЗБГЗГ	Холбогдох яамд, их сургуулид, ТББ-үүд
Хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, баттуулах	-	Хуулийн төслийдийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	-	Хуулийн төслийдийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	-	Хуулиудын хэрэгжилтийг хангаж ажиллах	-	БХБЯ, ГЗБГЗГ	-	Холбогдох яамд, их сургуулид, ТББ-үүд
Хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, баттуулах	-	Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	БХБЯ	ГЗБГЗГ	Холбогдох яамд, их сургуулид, ТББ-үүд
Хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, баттуулах	-	Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	БХБЯ	ГЗБГЗГ	НЭДТГ
Хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, баттуулах	-	Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	БХБЯ	ГЗБГЗГ	Холбогдох яамд
Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журмыг шинжилж боловсруулах	10.0	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах журмыг шинжилж баттуулах	-	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргахтай холбоотой норм, стандартыг боловсруулж, батлах	-	Холбогдох дүрэм, журам, норм, стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах	-	БХБЯ	ГЗБГЗГ	БОАЖЯ
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээ байгуулах чиглэлээр байгаль экологийн судалгаа хийж, бусад холбогдох сандбарын хяналтын цэгүүдэй холбох ажлыг гүйцэтгэх	500.0	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах /Улаанбаатар, Зүүн болон Төвийн бус/	250.0	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үндэсний мониторингийн сүлжээг байгуулах /Хангайн болон Баруун бус/	250.0	Мониторингийн сүлжээ байгуулах	-	ГЗБГЗГ	БХБЯ	БОАЖЯ, ХХААХУЯ, ШУА



ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
2.81. Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн зурагжуулах, шинчлэх, геодезийн нэгдсэн сүлжээг бий болгох замаар орон зайн өгөгдөл, мэдээллийн нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.	1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг тодотгох	2016-2018	-	-
	2	Монгол Улс, ОХУ-ын хоорондох хилийн цэсийг тодотгох, баталгаажуулах ажлыг зохион байгуулах	2016-2020	-	-
	3	Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах	2016-2020	Улсын төсөв, гадаад эх үүсвэр	36,000.0
	4	Монгол Улсын 63 сум, суурин газарт GNSS (GPS)-ийн байнгын ажиллаагатай суурин станц байгуулах	2016-2020	Улсын төсөв	4,500.0
	5	Газар зүйн нэрийн тодруулалтыг улсын хэмжээнд хийх	2016-2018	Улсын төсөв	3,000.0
	6	Өндрийн I ангийн сүлжээг шинээр байгуулах	2016-2018	Улсын төсөв	990.0
	7	Өндрийн II ангийн сүлжээний давтан хэмжилт хийх	2016-2019	Улсын төсөв	5,400.0
	8	Монгол Улсын геодезийн сүлжээний эхлэл цэгийг байгуулах	2016-2018	Улсын төсөв	300.0
	9	Төрөөс орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох	2016-2017	-	-
	10	Газар зүйн нэр, хаяг, геодезийн цэг тэмдэгт, хилийн цэсийн мэдээллийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх	2016-2018	Улсын төсөв	100.0
	11	Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх	2016-2020	Улсын төсөв	5,000.0
	12	Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах	2016-2020	Улсын төсөв	1,000.0
	13	Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх	2016-2020	Улсын төсөв	1,600.0



Хүрэх тувшин, үр дун (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)							Хэрэгжүүлэх байгууллага			
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Хүрэх тувшин, үр дунгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дунгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дунгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дунгийн үзүүлэлт	Төсөв			
Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн зургийг тодотгох, УИХ-д өргөн мэдүүлэх	-	Холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	БХБЯ	ГЭБГЗГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
ОХУ-ын холбогдох байгууллагатай зөвлөлийн техникийн даалгавар, албаны удирдажийн теслийг боловсруулах	-	ОХУ-ын холбогдох байгууллагатай хамтран хөөр улсын хилийн 50 хувийг М1:10000 масштабтай зурагаар зурагжуулж, хилийн цэсийг тодотгох	-	ОХУ-ын холбогдох байгууллагатай хамтран хөөр улсын хилийн 50 хувийг М1:10000 масштабтай зурагаар зурагжуулж, хилийн цэсийг тодотгох	-	Хоёр улсын хоорондох хилийн цэсийг УИХ-д өргөн мэдүүлэх, баттууллах	-	БХБЯ, ХЭДХЯ	БХЯ, ГХЯ, ГЭБГЗГ	Холбогдох агентлагууд
Нутаг дэвсгэрийн 25 хувийг зурагжуулах	17,000.0	Нутаг дэвсгэрийн 14 хувийг зурагжуулах	10,000.0	Нутаг дэвсгэрийн 16 хувийг зурагжуулах	9,000.0	Монгол Улсын нутаг дэвсгэрийг М1:25000 байр зүйн зурагаар бүрэн зурагжуулах	-	БХБЯ	ГЭБГЗГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
21 станцыг төлөвлөгөөний дагуу сууринтуулж ажиллагаанд оруулах	1,500.0	21 станцыг төлөвлөгөөний дагуу сууринтуулж ажиллагаанд оруулах	1,500.0	21 станцыг төлөвлөгөөний дагуу сууринтуулж ажиллагаанд оруулах	1,500.0	63 станц байгуулах	-	БХБЯ	ГЭБГЗГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
Нутаг дэвсгэрийн 40 хувийг хамарсан газар зүйн нарийн тодруулалтыг хийж, мэдээллийн сан үүсгэх	1,200.0	Нутаг дэвсгэрийн 30 хувийг хамарсан газар зүйн нарийн тодруулалтыг хийж, мэдээллийн сан үүсгэх	900.0	Нутаг дэвсгэрийн 30 хувийг хамарсан газар зүйн нарийн тодруулалтыг хийж, мэдээллийн сан үүсгэх	900.0	Нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан газар зүйн нарийн тодруулалтыг хийж, мэдээллийн сан үүсгэх	-	БХБЯ	ГЭБГЗГ	ШУА, аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
I ангийн сүлжээг байгуулах	990.0	-	-	-	-	Монгол Улсад өндрийн I ангийн сүлжээг бүрэн байгуулах, баттуулан, хэрэглэгчдад хэрэг ажлыг зохион байгуулах	-	БХБЯ	ГЭБГЗГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
Төв болон Говийн бүсийн нутаг дэвсгэрийн 10537 км шугамын дагуу II ангийн сүлжээг шинчлэх	2,700.0	Баруун болон Говийн бүсийн нутаг дэвсгэрийн 10537 км шугамын дагуу II ангийн сүлжээг шинчлэх	2,700.0	-	-	II ангийн 21074 км сүлжээг шинчлэх	-	БХБЯ	ГЭБГЗГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
Эхлэл цагийг байгуулах	300.0	-	-	-	-	Монгол Улсын төв хэсэгт геодезийн байрлал өндрийн сүлжээнийн эхлэл цагийг байгуулик, ОХУ, БНХАУ-ын сүлжээтэй холбох	-	БХБЯ	ГЭБГЗГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
Бодлогын баримт бичигийг боловсруулж, баттууллах	-	-	-	-	-	-	-	БХБЯ	ГЭБГЗГ	Холбогдох яамд, их сургуулиуд, ТББ-үүд
Улсын хамжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх байгаа мэдээллийн нэгтгэн цахим хэлбэрт оруулах, ўйчилгээнд нэвтрүүлэх	100.0	-	-	-	-	Газар зүйн нэр, хаяг, геодезийн цаг тэмдэгт, хилийн цэсийн мэдээллийг цахим хэлбэрээр ўйчилгээнд нэвтрүүлэх	-	БХБЯ	ГЭБГЗГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
Улсын хамжээнд орон зайн егэгдлийн дэд бүтгүүн стратегийн боловсруулж, техник хангамжийг шийдвэрлэх	3,000.0	Төрийн байгууллагудын орон зайн мэдээллийг нэг стандартад хөрүүлж, сурь мэдээллийг бүрдүүлж	1,000.0	Геопорталаар дамжуулсан орон зайн сурь егэгдэл бүхий мэдээллийг төрийн болон нийтийн газар ангиллаар түгээж эхлэх	1,000.0	Геопорталыг байгуулагдах	-	БХБЯ	Холбогдох яамд, агентлагууд	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
Холбогдох сурь егэгдлийн нэгдсан системд оруулах нэцүүлийн бурдуулж, мэргэжлийн программын хангамжийг нэвтрүүлах эрх зүйн орчныг бий болгох	800.0	Газар зохион байгуулалт, газрын кадастрын мэдээллийн мэдээллийн сангийн программын хангамжийг 21 аймаг, 330 сумаанд нэвтрүүлэх	200.0	Үндэсний орон зайн мэдээллийн нэгдсан санг бурдуулж, ашиглах	-	Нэгдсан систем бурдаж, цахим хэлбэрээр ўйчилгээнд нэвтрэх	-	ГЭБГЗГ	Холбогдох яамд, агентлагууд	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг Лэнд менежер программын хангамжийг шилжүүлэх албаны хэрэгжүүлж, ўйчилгээнд нэвтрүүлах	1,500.0	Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг иргэд, илон нийтэд цахим хэлбэрээр хургах, ўйчилгээнд зуужлах	100.0	Улсын кадастрын мэдээллийн дад бүтцийн сурь егэгдлийг бурдуулж	-	Улсын кадастрын нэгдсан систем бурдаж, иргэд цахим ўйчилгээнд авах боломжийт болох	-	ГЭБГЗГ	Холбогдох яамд, агентлагууд	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд



ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
2.82. Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бурдуулна.	1	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2016-2017	-	-
	2	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотголын дагуу бүсчлэлийн төлөвлөлт, инженер геологи, газар хөдлөлтийн болон газар дээрх, доорх шугам сүлжээний зураглал хийж, мэдээллийн сан уусган, муухалын нарийвчилсан зураг тесел боловсруулах	2016-2018	Улсын төсөв	251.8
2.83. Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан "Гудамж", "Дугуйн зам" дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	1	УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтооолор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах	2016-2020	-	-
	2	"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг зохион байгуулах	2016-2020	-	-
2.84. Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн ногоон байгууламжийг З дахин нэмэгдүүлэх болдого баримтална.	1	Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг боловсруулах	2016-2017	-	-
2.85. Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх боллогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн тесел, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бурдуулна.	1	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан гарах дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах	2016-2020	-	-
	2	Хувийн хэвшилтэй хамтран "Хот байгуулалтын форум", "Газрын харилцаа, геодези, зураг зүйн форум"-ыг тогтмол зохион байгуулах	2016-2020	Улсын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	200.0
	3	Хөшигийн хөндийд баригдах олон улсын нисэх буудлыг даган бий болох "ухаалаг" жишиг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	2017-2019	Улсын төсөв	633.0
	4	Аймгийн төв болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2017-2020	Улсын төсөв	5,068.5
	5	Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх	2016-2020	Улсын төсөв	11,280.0



Хүрэх тувшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)								Хэрэгжүүлэх байгууллага		
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв			
Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх		Хуулийн хэрэгжилтийг хангуулах		Хуулийн хэрэгжилтийг хангуулах		Хуулийн хэрэгжилтийг хангуулах		БХБЯ	НЭДТГ	Холбогдох яамд, ТББ-үүд
Мэдээллийн сан байгуулж, мухалын нарийвчилсан зураг төслийг боловсруулах	251.8	-	-	-	-	-	-	БХБЯ	НЭДТГ	ГЗБГЗГ
-	-	Хэрэгжилтийг дүгнэж, УИХ-д өргөн мэдүүлэх	-	-	-	Хэрэгжилтийг дүгнэж, УИХ-д өргөн мэдүүлэх	-	БХБЯ	НЭДТГ	Холбогдох яамд, агентлагууд
Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	НЭДТГ	БХБЯ, МХЕГ	Холбогдох яамд, агентлагууд
Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	-	-	-	-	-	-	-	БХБЯ, БОАЖЯ	НЭДТГ	Холбогдох яамд, агентлагууд
Холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулж, баттуулах	-	Дүрэм, журам, заавар, аргачлалын хэрэгжилтийг зохион байгуулах	-	Дүрэм, журам, заавар, аргачлалын хэрэгжилтийг зохион байгуулах	-	Дүрэм, журам, заавар, аргачлалын хэрэгжилтийг зохион байгуулах	-	БХБЯ	ХЭДХЯ, БХТ, ГЗБГЗГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд
Хувийн хэвшил болон холбогдох ТББ-тай хамтран 2 жилд 1 удаа зохион байгуулах	100.0	-	-	Хувийн хэвшил болон холбогдох ТББ-тай хамтран 2 жилд 1 удаа зохион байгуулах	100.0	-	-	БХБЯ	БХТ, ГЗБГЗГ	ТББ-үүд, ААН-үүд
Жишиг "ухаалаg" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, баттуулах	451.6	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	181.4	-	-	-	-	БХБЯ	СЯ, ЗТХЯ	Төв аймгийн ЗДТГ
Багануур хот болон Сүхбаатар, Говь-Алтай, Дундговь, Ус үс аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, Дархан-Уул, Завхан, Орхон, Хэнтий, Архангай, Булган, Өвөрхангай, Дархан-Уул аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	-	Завхан, Орхон, Хэнтий, Архангай, Булган, Өвөрхангай, Дархан-Уул аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	4,341.3	Хархорин хотыг байгаль орчинд залтэй хот болгон хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	727.2	-	-	БХБЯ	СЯ, БОАЖЯ, ЗТХЯ	Холбогдох аймгийн ЗДТГ-үүд
Ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх	3,000.0	Ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх	3,000.0	Ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх	3,000.0	Ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх	2,280.0	БХБЯ	МХЕГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд



ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
2.86. Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ.	1	Аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2016-2018	Улсын төсөв	3,000.0
	2	Инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын системээр төлөвлөх стандарт боловсруулах	2016-2020	Барилга, байгууламжийн норм, нормативын сан	10.0
	3	Үс хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний наасжилтийг уртастгах, шинэчлэх, засварлах ажилд шинэ дэвшилтэй технологийг нэвтрүүлэх	2016-2020	Гадаад зээл	17,820.0
2.87. Барилга байгууламжийн өөрийн өргтгийг бууруулах, барилгын үйлдвэрлэлийн хугацааг уртасгах, барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулахад чиглэсэн барилтын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	1	Үгсармал барилгын үйлдвэрлэлийг дэмжих	2017-2020	Гадаад зээл	14,000.0
	2	Барилгын жинг хөнгөрүүлэх, дулаан алдагдлыг бууруулах, галд тэсвэрлэлтийг сайжруулахад чиглэсэн байгаль орчинд эзлтэй барилгын дулаалгын материалын үйлдвэрүүдийг бодлогоор дэмжих	2017-2020	Гадаад зээл	9,700.0
	3	Шилний үйлдвэр байгуулах төслийг бодлогоор дэмжих	2017-2020	Гадаад зээл	8,000.0
	4	Баруун бүсэд байгуулах цементийн үйлдвэрийг дэмжих	2017-2020	Гадаад зээл	61,300.0
2.88. Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтэд тусгах, ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ.	1	Улаанбаатар хот, Налайх, Багануур, Багахангай дүүргүүдийн 1:10000 масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалд үндэслэн газар хөдлөлтийн барилгын норм, дүрмийг шинэчлэх	2017-2018	Барилга, байгууламжийн норм, нормативын сан	3.0
	2	Аймаг, сум, суурин газруудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажлыг хийж дуусгах	2016-2019	Улсын төсөв	2,082.0
	3	Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг хэрэгжүүлэх	2016-2020	Улсын төсөв	6,000.0



Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)								Хэрэгжүүлэх байгууллага		
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв			
Аймаг бүрт 1000 айлын орон сууц төсөл хэрэгжих нөхцөл бүрдэх	1,500.0	Хүн амын ажиллаж, амьдрах таатай нөхцөл, хот, суурин газар өргөжин тэлэх боломж бүрдэх	1,500.0	-	-	-	-	БХБЯ	ЭХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд	Аймгийн ГХБХБГ-үүд
Стандартын техникийн даалгаврыг батлуулж, ажлыг эхлүүлэх	5.0	Ажлын гүйцэтгэлийг 40-50 хувьд хургэх	3.0	Стандартын төслийг боловсруулж дуусгах	2.0	-	-	БХБЯ	СХЭГ	-
Шуудагчийн агаар сэргээн засварлах төсөл хэрэгжүүлэх балтгэл ажлыг хангах	4,455.0	Улаанбаатар хотын цэвэр, бохир усны 24 км шугам сүлжээнд доторлогоо хийх	4,455.0	Улаанбаатар хотын цэвэр, бохир усны 24 км шугам сүлжээнд доторлогоо хийх	4,455.0	Инженерийн шугам сүлжээний ашиглалт, ус хангамжийн чанар сайжирч, шинэ технологи нэвтрэх	4,455.0	БХБЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ-үүд	-
Угсармал барилгын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих	14,000.0	Угсармал хийц бүтээцийн шинэ давшилтэт техники, технологи нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	-	Угсармал барилгын үйлдвэрлэл шинэ техники, технологи нэвтрэх	-	Барилгын үйлдвэрлэл жилийн турш үргэлжлэх нөхцөл бүрдэх	-	БХБЯ	-	ААН-үүд
Барилын ажлыг эхлүүлэх	6,857.2	Цагаанчлуут багт 280 хүүхдийн сургууль цэцэрлэгийн цогцолбор, Согоот багт 280 хүүхдийн цэцэрлэг, 640 хүүхдийн сургууль, Яргуйт багт 150 хүүхдийн цэцэрлэг баригдах	7,230.0	Рашаант багт 150 хүүхдийн цэцэрлэг, Шанд багт 150 хүүхдийн цэцэрлэг, Уртын гол багт 150 хүүхдийн цэцэрлэг баригдах	2,090.0	Даваат багт 150 хүүхдийн цэцэрлэг баригдах	380.0	БСШУСЯ	Аймгийн ЗДТГ			
	1,000.0		1,000.0		1,000.0	Соёл спортын төв өөрийн байртай болх, үйл ажиллагааны хүртээмжийн сай突如其来, нийт үйлчлүүлэгчдийн тоо жилд 35000, урлаг соёл, спортын арга хэмжээ 500-д хүрэх		БСШУСЯ	Аймгийн ЗДТГ			
Өрхийн зруул мэндийн 1 цопц төв баригдах	1,500.0	Өрхийн зруул мэндийн 1 цопц төв баригдах	1,500.0					ЭМЯ	Аймгийн ЗДТГ			
Яаралтай түргэн тусламжийн төвтэй болох	1,550.0	Тоног төхөөрөмжийн хангарт хийгдэн, тусламж үйлчилгээний чадавхи сай突如其来	50.0	Тоног төхөөрөмжийн хангарт хийгдэх	50.0	Тоног төхөөрөмжийн хангарт хийгдэх	50.0	ЭМЯ	Аймгийн ЗДТГ			
1 төв байгуулах	1,000.0	1 төв байгуулах	1,000.0	1 төв байгуулах	1,000.0	1 төв байгуулах	1,000.0	ХНХЯ	Аймгийн ЗДТГ			
	1,500.0		1,000.0		500.0	Музейн барилгатай болх, үйлчилгээний чанар хүртээмжийн сай突如其来, соёлын биет өвийг эрдээнд орохос сэргийлэх, нийт үзүч, үйлчлүүлэгчдийн тоо жилд 322000, урлаг соёлын арга хэмжээ 1600-д хүрэх		БСШУСЯ	Аймгийн ЗДТГ			
Зураг төсвийн ажил хийгдэх	18.0	Барилын ажил хийгдэх	600.0	Зориулалтын тоног төхөөрөмжийн хангант ашиглалтад оруулах	300.0	Хүн амын төмс хүнсний ногооны хангамжийг жилийн түрш жигд тогтвортой хангах		ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ			



ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
6.13. Өвөрхангай аймаг					
1. Хархорин-Хужирт-Арвайхээр чиглэлийн 40 км авто замыг шинээр барих зураг төсөл боловсруулж, барьж эхлнэ.	1	Хужирт-Төвхэн хийд-Улаан цутгалан, Хархорин-Хужирт-Арвайхээр чиглэлийн авто замыг шинээр барих	2017-2019	Улсын төсөв	34,000.0
2. Арвайхээр хотод дулааны цахилгаан станц шинээр барих асуудлыг судалж, шийдвэрлэнэ.	2	Арвайхээр хотыг дулааны үйлдвэрлэлээр бүрэн хангах дулааны станцыг шинээр барих	2017-2018	Гадаад эх үүсвэр	24,000.0
6.14. Өмнөговь аймаг					
1. Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай автозам барих ажлыг үргэлжлүүлж дуусгана.	1	Өмнөговь аймгийн Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлж дуусгах	2016-2020	Улсын төсөв	200,000.0
2. Даланзадгад-Цогтцэций чиглэлийн хатуу хучилттай автозам барих ажлыг үргэлжлүүлж дуусгана.	2	Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Шар тээг-Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлж дуусгах	2016-2019	Төр, хувийн хэвшлийн түншлэл	40,700.0
6.15. Сүхбаатар аймаг					
1. Ноолуур, ноос угаах самнах, ээрэх зэрэг хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ.	1	Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах төв байгуулах	2017-2020	Улсын төсөв	4,050.0
2. Аймгийн төвд дулааны станц байгуулна.	1	Дулааны станцын өргөтгөл /2 дугаар шат, 32 МВт болгон өргөтгэх, Сүхбаатар, Баруун-Урт/	2017-2020	Улсын төсөв	6,000.0
6.16. Сэлэнгэ аймаг					
1. Орон нутгийн чанартай нийт 200 км автозамыг барьж байгуулна.	1	Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн олон улсын авто замаас Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг чиглэлийн 112 км авто зам барих	2016-2018	Улсын төсөв	44,800.0
	2	Дархан-Эрдэнэтийн чиглэлийн замаас Орхонтуул сумын төв хүртэл 65 км хатуу хучилттай авто зам барих	2017-2018	Улсын төсөв	26,000.0
	3	Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замаас Мандал сумын төв хүртэл 32 км хатуу хучилттай авто зам барих	2017-2018	Улсын төсөв	18,800.0
	4	Дархан-Сэлэнгийн хатуу хучилттай авто замаас Хушаат сумын төв хүртэл 26 км хатуу хучилттай авто зам барих	2018-2019	Улсын төсөв	10,400.0
	5	Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр сумын төв хүртэл 45 км хатуу хучилттай авто зам барих	2019-2020	Улсын төсөв	18,000.0
	6	Аймгийн төв Сүхбаатар сумын өрөнхий төлөвлөгөөний дагуу төв дотор 34 км хатуу хучилттай авто зам барих	2017-2020	Улсын төсөв	13,600.0
	7	Сумдын төвийн хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлэх	2017-2020	Улсын төсөв	12,500.0



Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)								Хэрэгжүүлэх байгууллага		
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв			
6.13. Өвөрхангай аймаг										
-	-	Ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх	17,000.0	Ажлыг бурэн дуусгах	17,000.0	-	-	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	"Өвөрхангай АЗЗА" ТӨХХ
Ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хүргэх	8,000.0	Ажлыг бурэн дуусгах	16,000.0	-	-	-	-	ЭХЯ	Аймгийн ЗДТГ	-
6.14. Өмнөговь аймаг										
Ажлын гүйцэтгэлийг 25 хувьд хүргэх	50,000.0	Ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх	50,000.0	Ажлын гүйцэтгэлийг 75 хувьд хүргэх	50,000.0	Ажлыг бурэн дуусгах	50,000.0	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
Ажлын гүйцэтгэлийг 33 хувьд хүргэх	13,500.0	Ажлын гүйцэтгэлийг 67 хувьд хүргэх	13,500.0	Ажлыг бурэн дуусгах	13,700.0	-	-	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
6.15. Сүхбаатар аймаг										
Төвийн үйл ажиллагаа эхлэх	1,850.0	Төвийн үйл ажиллагаа жигдэрх	600.0	Төвийн үйл ажиллагаа жигдэрх	1,000.0	ХАА-н боловсруулах үйлдвэрүүд байгуулагдах	600.0	ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	-
-	-	ТЭЗҮ хийгдэх	-	Барилгын ажлыг эхлүүлэх	3,000.0	Барилгын ажлыг дуусгах	3,000.0	ЭХЯ	Аймгийн ЗДТГ	-
6.16. Сэлэнгэ аймаг										
Замын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	24,000.0	Замын барилга угсралтыг дуусгах, ашиглалтад оруулах	20,800.0	-	-	-	-	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
Зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах	150.0	Замын барилга угсралтыг дуусгах, ашиглалтад оруулах	25,850.0	-	-	-	-	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
Зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах	75.0	Замын барилга угсралтыг дуусгах, ашиглалтад оруулах	18,725.0	-	-	-	-	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
-	-	Зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах	70.0	Замын барилга угсралтыг дуусгах, ашиглалтад оруулах	10,330.0	-	-	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
-	-	-	-	Зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах	85.0	Замын барилга угсралтыг дуусгах, ашиглалтад оруулах	17,915.0	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
Хатуу хүчинтэй замын ажлыг эхлүүлэх	4,000.0	Хатуу хүчинтэй замын ажлыг үргэлжлүүлэх	4,000.0	Хатуу хүчинтэй замын ажлыг үргэлжлүүлэх	4,000.0	Хатуу хүчинтэй замын ажлыг дуусгах	1,600.0	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
Мандал, Сайхан, Цагаанuur сумдын төвийн хатуу хүчинтэй авто замын сүлжээг нэмэгдүүлэх	6,000.0	Алтанбулаг, Баянгол, Баруунбүрэн, Орхонтуул сумдын төвийн хатуу хүчинтэй авто замын сүлжээг нэмэгдүүлэх	2,000.0	Орхон, Сант, Шаамар, Зүүнбүрэн сумдын төвийн хатуу хүчинтэй авто замын сүлжээг нэмэгдүүлэх	2,000.0	Ерөө, Хүдэр, Жавхлант, Түшиг, Хуваат сумдын төвийн хатуу хүчинтэй авто замын сүлжээг нэмэгдүүлэх	2,500.0	ЗТХЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд



ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
3. Сум бүрт төмс хүнсний ногооны зоорь барьж, ногоог жилийн туршид хадгалах, борлуулах боломжийг бүрдүүлнэ.	1	Сум бүрт төмс, хүнсний ногооны зоорь барих	2017-2019	Орон нутгийн төсөв	1,800.0
	2	Улаанбаатар хотод Сэлэнгэ аймгийн ногоочдын төмс, хүнсний ногоо хадгалах нэгдсэн зоорь барих /1000 тн/	2017	Орон нутгийн төсөв	1,150.0
4. Сүхбаатар, Мандал, Сайхан суманд сүүний үйлдвэр, бусад сумдад сүү хөргөх төхөөрөмж бүхий цех байгуулах.	1	Сүхбаатар, Мандал, Сайхан сумдад сүүний үйлдвэр, бусад сумдад сүү хөргөх төхөөрөмж бүхий цех байгуулах	2017-2019	Улсын төсөв	3,000.0

6.17. Төв аймаг

1. Төв аймгийн Зуунмод хотын дулааны станцыг байгуулах ажлыг эхлүүлж, гэр хорооллын айл өрхийг нэгдсэн дулаан, цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ.	1	Дулааны станцын ТЭЗҮ-ийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	2017	Улсын төсөв	24,300.0
	2	Дулааны станц барих бэлтгэл ажлын хүрээнд Зуунмод сумын газар доорхи инженерийн шугам сүлжээг шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2017-2020		
	3	Дулааны станц барих хөрөнгийн асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэн, ашиглалтад оруулах	2017-2020		
2. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлэх аж ахуйн нэгж, иргэдийг дэмжинэ.	1	Малын тэжээлийн тариалалтын бүс нутгийг тогтоож, тэжээлийн ургамлын үрийн нөөцтэй болгох, малын тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлж, эрчимжсэн аж ахуйн тэжээлийн хөрөгцээг хангах, малын тэжээлийн үйлдвэрийг 5-с доошгүй сумдад байгуулах	2017-2020	Улсын төсөв	750.0

6.18. Увс аймаг

1. Увс аймгийн Улаангом суманд оношилгооний төв, хүүхдийн эмнэлэг, эхийн амрах барих асуудлыг судлан шийдвэрлэж, эх хүүхдийн тусламж	1	Хүүхдийн эмнэлэг шинээр барих /80 ор, Улаангом/	2018-2019	Улсын төсөв	4,500.0
	2	Эхийн амрах байрны барилга /20 ор/	2019-2020	Улсын төсөв	4,500.0
2. Увс аймгийн Улаангом суманд спорт, чийрэгжүүлэлтийн төв барих асуудлыг судлан шийдвэрлэнэ.	1	Аймгийн төвд 150-иас доошгүй суудалтай фитнес /чийрэгжүүлэлтийн/ төв, нэг зэлжиннд 50 хүн орох усан бассейн барих	2017-2019	Улсын төсөв	4,300.0
3. Малын гаралтай түүхий эд, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	1	Дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр байгуулах	2018	Гадаад эх үүсвэр	3,500.0
	2	Сүүний үйлдвэр байгуулах	2019	Гадаад эх үүсвэр	2,000.0
	3	Хүнсний ногоог вакуумжуулсан аргаар боловсруулах үйлдвэр байгуулах	2018	Гадаад эх үүсвэр	1,000.0
	4	Малын арьс шир, ноос боловсруулах үйлдвэр байгуулах	2018-2019	Гадаад эх үүсвэр	3,000.0
	5	Чацарганыг кластержуулж хөгжүүлэх, боловсруулах үйлдвэрийн технологийг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх	2017-2018	Гадаад эх үүсвэр	3,000.0



Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)								Хэрэгжүүлэх байгууллага		
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв			
6 суманд барих	600.0	6 суманд барих	600.0	5 суманд барих	600.0	-	-	ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
Зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах	150.0	Барилгын ажлыг эхлүүлэх	300.0	Барилгын ажлыг дуусах	700.0	-	-	ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд
Мандал суманд үйлдвэр, Ерөө, Худэр сүмдад цех байгуулах	1,000.0	Сүхбаатар суманд үйлдвэр, зэрэглээх 4 суманд цех байгуулах	1,000.0	Сайхан суманд үйлдвэр, зэрэглээх 5 суманд цех байгуулах	1,000.0	-	-	ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ-үүд

6.17. Төв аймаг

TЭЗҮ хийгдэх								ЭХЯ	Аймгийн ЗДТГ	
Зураг төсөл хийгдэх		Тухайн жилийн төвлөвлөөг хэрэгжүүлах	15,000.0	Тухайн жилийн төвлөвлөөг хэрэгжүүлах	5,000.0	Тухайн жилийн төвлөвлөөг хэрэгжүүлах	4,300.0	ЭХЯ	Аймгийн ЗДТГ	
		Ажлын гүйцэтгэлийг 10 хувьд хүргэх		Ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх		Ажлыг бүрэн дуусах		ЭХЯ	Аймгийн ЗДТГ	
Малын тажээлийн үйлдвэр 2 суманд байгуулах	300.0	Малын тажээлийн үйлдвэр 2 суманд байгуулах	300.0	Малын тажээлийн үйлдвэр 5 суманд байгуулах	150.0	Сумдад байгуулсан 5 үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэх	-	ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	

6.18. Увс аймаг

		Ажлын гүйцэтгэлийг 60 хувьд хүргэх	2,500.0	Ажлыг бүрэн дуусах	2,000.0			ЭМЯ	Аймгийн ЗДТГ	
				Ажлын гүйцэтгэлийг 60 хувьд хүргэх	2,500.0	Ажлыг бүрэн дуусах	2,000.0	ЭМЯ	Аймгийн ЗДТГ	
Ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хүргэх	1,000.0	Ажлын гүйцэтгэлийг 80 хувьд хүргэх	2,000.0	Ажлыг бүрэн дуусах	1,300.0			ЭМЯ	Аймгийн ЗДТГ	
		Ажлыг бүрэн дуусах	3,500.0					ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	
				Ажлыг бүрэн дуусах	2,000.0			ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	
		Ажлыг бүрэн дуусах	1,000.0					ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	
		Ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэх	1,000.0	Ажлыг бүрэн дуусах	2,000.0			ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	
Ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэх	1,000.0	Ажлыг бүрэн дуусах	2,000.0					ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	



ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
6.19. Ховд аймаг					
1. Чоно хайхын гүүрийг ашиглалтад оруулна. /Дөргөн сүм/	1	Чоно хайхын гүүрийг ашиглалтад оруулах /Дөргөн сүм/	2017-2018	Улсын төсөв	1,500.0
2. Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр баруун бүсийн босоо тэнхлэгийн автозам барина. /Өлгий-Ховд, 100 км/	2	Баруун бусийн босоо тэнхлэгийн авто зам барих /Өлгий-Ховд 100 км/	2016-2018	Гадаад зээл	86,300.0
3. Олон улсын нисэх буудлын барилгыг өргөтгөнө.	3	Олон улсын нисэх буудлын барилгыг өргөтгөх	2017-2018	Улсын төсөв	10,000.0
4. Эрдэнэбүрэнгийн Шижигтийн усан цахилгаан станцыг барьж, ашиглалтад оруулна.	4	Эрдэнэбүрэнгийн Шижигтийн усан цахилгаан станцыг барьж, ашиглалтад оруулах	2017-2020	Улсын төсөв, гадаад эх үүсвэр, тер, хувийн хэвшлийн түншлэл	600,000.0
5. Хүүхдийн 50 ортой эмнэлгийн барилга барина. /Жаргалант сүм/	5	Хүүхдийн 50 ортой эмнэлгийн барилга барих /Жаргалант сүм/	2017-2018	Улсын төсөв	5,000.0
6. Цементийн үйлдвэр барина. /Жаргалант сүм/	6	Цементийн үйлдвэр барих /Жаргалант сүм/	2017-2018	Улсын төсөв	110,000.0
7. Малын гаралтай түүхий эд болон ноос ноолуур боловсруулах үйлдвэр байгуулна.	7	Малын гаралтай түүхий эд болон ноос ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах	2017-2018	Улсын төсөв	6,000.0
8. Цэвэр, бохир усны 15 км газар доорх шугам шинэчилнэ. /Жаргалант сүм/	8	Цэвэр, бохир усны 15 км газар доорх шугам шинэчлэх /Жаргалант сүм/	2018-2019	Улсын төсөв	4,500.0
9. Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын цэвэрлэх байгууламж барина.	9	Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын цэвэрлэх байгууламж барих	2017	Улсын төсөв	1,500.0
6.20. Хөвсгөл аймаг					
1. Мөрөн хотыг тойрсон хөдөө аж ахуй, үйлдвэр технологийн паркууд байгуулна.	1	Мод боловсруулах үйлдвэр байгуулах	2017-2019	Улсын төсөв	3,093.2
	2	Хөвсгөл бренд бүтээгдэхүүн, бэлэг дурсгал, гоёл чимэглэлийн үйлдвэр байгуулах	2017-2019	Улсын төсөв	1,000.0



Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)								Хэрэгжүүлэх байгууллага		
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв			
6.19. Ховд аймаг										
Зураг төсвийн дагуу тендер зарлаж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хургэх	700.0	Ажлыг бүрэн дуусгаж, хүлээн авах	800.0	-	-	-	-	ЭТХЯ	Аймгийн ЗДТГ	-
Газар широоны ажлыг дуусгах, хүчинтын ажлыг дуусгах ашиглалтад оруулах	86,300.0	-	-	-	-	-	-	ЭТХЯ	Аймгийн ЗДТГ	-
Зураг төсвийн дагуу тендер зарлаж, ажлын гүйцэтгэлийг 30 хувьд хургэх	3,000.0	Ажлыг бүрэн дуусгаж, улсын комисс хүлээн авах	7,000.0	-	-	-	-	ЭТХЯ	Аймгийн ЗДТГ	-
Зураг төсвийн дагуу тендер зарлаж, ажлыг эхлүүлах	1,000.0	Ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хургэх	150,000.0	Ажлын гүйцэтгэлийг 80 хувьд хургэх	250,000.0	Ажлыг бүрэн дуусгаж, хүлээн авах	199,000.0	ЭХЯ	Аймгийн ЗДТГ	-
Зураг төсвийн дагуу тендер зарлаж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хургэх	2,500.0	Ажлыг бүрэн дуусгаж, улсын комисс хүлээн авах	2,500.0	-	-	-	-	ЭМЯ	Аймгийн ЗДТГ	-
Зураг төсвийн дагуу тендер зарлаж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хургэх	50,000.0	Ажлыг бүрэн дуусгаж, хүлээн авах	60,000.0	-	-	-	-	БХБЯ	Аймгийн ЗДТГ	-
Зураг төсвийн дагуу тендер зарлаж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хургэх	3,000.0	Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах	3,000.0	-	-	-	-	ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	-
		Зураг төсвийн дагуу тендер зарлаж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хургэх	2,000.0	Ажлыг бүрэн дуусгаж, улсын комисс хүлээн авах	2,500.0	-	-	БХБЯ	Аймгийн ЗДТГ	-
ХАА-н гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах	1,500.0	-	-	-	-	-	-	ХХААХҮЯ	Аймгийн ЗДТГ	-
6.20. Хөвсгөл аймаг										
Барилга баригдах	1,500.0	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татах	1,000.0	Зүсмэл хатаалга, шахмал түлш, модон тавилгын цехүүдийг ашиглалтад оруулах	593.2	-	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Барилга баригдах	200.0	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татах	250.0	-	250.0	-	300.0	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд



ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
1. Мөрөн хотыг тойрсон хөдөө аж ахуй, үйлдвэр технологийн паркууд байгуулна.	3	Аялал жуулчлалын цогцолбор байгуулах	2017-2020	Улсын төсөв	717.0
	4	Цэвэр усны үйлдвэр байгуулах	2017-2019	Улсын төсөв	1,500.0
	5	Оёдлын үйлдвэр байгуулах	2017-2019	Улсын төсөв	1,450.0
	6	Ноос ноолуур боловсруулах үйлдвэр байгуулах	2017-2019	Улсын төсөв	1,500.0
	7	Сүлжмэлийн үйлдвэр байгуулах	2017-2019	Улсын төсөв	1,300.0
	8	Нарийн ногооны өвлүүн хүлэмжийн аж ахуй байгуулах	2017-2020	Улсын төсөв	1,350.0
	9	Мах сүүний аж ахуйн фермер байгуулах	2017-2020	Улсын төсөв	1,100.0
	10	Зөгийн аж ахуй байгуулах	2017-2020	Улсын төсөв	1,500.0
	11	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл байгуулах	2017-2020	Улсын төсөв	1,700.0
	12	Стандартын шаардлага хангасан агуулах, тээвэрлэлт бүхий худалдааны нэгдсэн төвийг байгуулах	2017-2020	Улсын төсөв	2,000.0
	13	Мал нядалгааны үйлдвэрлэл байгуулах	2017-2020	Улсын төсөв	1,500.0
	14	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл технологийн парк байгуулахад шаардагдах хатуу хучилттай авто зам барих /30 км/	2017-2020	Улсын төсөв	25,500.0
	15	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл технологийн парк байгуулахад шаардагдах цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх /35 кВт, 15 км/	2017-2020	Улсын төсөв	780.0



Хүрэх тувшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)							Хэрэгжүүлэх байгууллага			
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх тувшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв			
Барилга баригдах	617.0	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татах	100.0	-	-	-	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Барилга баригдах	1,000.0	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татах	500.0	-	-	-	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Барилга баригдах	1,000.0	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татах	300.0	-	150.0	-	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Барилга баригдах	1,000.0	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татах	500.0	-	-	-	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Барилга баригдах	1,000.0	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татах	300.0	-	-	-	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Судалгааны ажил хийгдэх	-	Барилга баригдах	1,000.0	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татах	350.0	-	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Судалгааны ажил хийгдэх	-	Барилга баригдаж эхлэх	-	Үйлдвэрийн тоног төхөөрөмж, сүүний чиглэлийн үхэр авах	1,100.0	Үйл ажиллагаа явуулж эхлэх, орон нутгийн хэргэцэнд нийлүүлж эхлэх	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Судалгааны ажил хийгдэх	-	Зээлий үргүүлгийн зоорь баригдаж эхлэх	500.0	Тоног төхөөрөмж, зэгийн булуудыг авч эхлэх	500.0	Үйл ажиллагаа явуулж эхлэх, орон нутгийн хэргэцэнд нийлүүлж эхлэх	500.0	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Судалгааны ажил хийгдэх	-	Барилга баригдаж эхлэх	700.0	Тоног төхөөрөмжийг татах	500.0	Үйл ажиллагаа явуулж эхлэх, орон нутгийн хэргэцэнд нийлүүлж эхлэх	500.0	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Судалгааны ажил хийгдэх	-	Барилга баригдаж эхлэх	1,000.0	Нэгдсэн худалдааны төвийн барилга баригдаж үйл ажиллагаа явагдаж эхлэх	1,000.0	-	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Судалгааны ажил хийгдэх	-	Барилга баригдаж эхлэх	1,000.0	Тоног төхөөрөмжийг татах	500.0	Үйл ажиллагаа хэвийн явагдаж тогтвортой	-	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, БОАЖГ, ГХБХБГ	ААН-үүд
Судалгааны ажил хийгдэх	-	ТЗҮ-ийг боловсрууллах	8,500.0	Зам барих ажлыг эхлүүлэх	8,500.0	Замыг ашиглалтад оруулах	8,500.0	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, ГХБХБГ	ААН-үүд
Судалгааны ажил хийгдэх	-	ТЗҮ-ийг боловсрууллах	260.0	Эрчим хүчинд холбох ажлыг эхлүүлэх	260.0	Цахилгааны эх үүсвэрийг шийдвэрлэх	260.0	Аймгийн ЗДТГ	Аймгийн ХХААГ, ГХБХБГ	ААН-үүд



ЗГУАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)
6.21. Хэнтий аймаг					
1. Даланжаргалан сумаас Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хүчилттай зам барина.	1	Даланжаргалан сумаас Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хүчилттай зам барих	2017-2020	Улсын төсөв	25,000.0
2. 21:100 хөтөлбөрийн хүрээнд арьс шир боловсруулах, ноос ноолуур угаах үйлдвэрийг барихыг дэмжинэ.	1	Арьс, шир боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	2017-2020	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	15,000.0
3. Хэнтий аймгийн Чингис хотод цэвэрлэх байгууламж шинээр барина.	1	Хэнтий аймгийн Чингис хотод цэвэрлэх байгууламж шинээр барих	2017-2020	Улсын төсөв	7,500.0



Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)								Хэрэгжүүлэх байгууллага		
2017 он		2018 он		2019 он		2020 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв			
6.21. Хэнтий аймаг										
Барилга угсралтын ажлыг эхлүүлэх	10,000.0	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрэх		10,000.0	Барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах		5,000.0	-	-	ЗТХЯ
Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 25 хувьд хүрэх	3,700.0	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрэх		3,700.0	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 хувьд хүрэх		3,700.0	Үйлдвэр ашиглалтад орох	3,900.0	ХХААХҮЯ
Барилга угсралтын ажлыг эхлүүлэх	3,000.0	Барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах		4,500.0	-		-	-	-	БХБЯ



ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ



**МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2016 оны 10 сарын 25 өдөр

Дугаар A-291

Улаанбаатар хот

Г Орон сууцны ипотекийн санхүүжилтийн
журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Улсын Их Хурлын 2016 оны 40 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тушаалын 1-д заасан журмыг орон сууцны ипотекийн хөнгөлөлтгэй хүүтэй зээлийн үйл ажиллагаанд мөрдэж ажиллахыг Мөнгөний бодлогын газар (Б.Баярдаваа), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (Э.Анар), бүх банкны гүйцэтгэх захиралд тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А-67 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тушаалыг мөрдлөг болгож ажиллахыг Мөнгөний бодлогын газар (Б.Баярдаваа), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (Э.Анар), бүх банкны гүйцэтгэх захиралд тус тус даалгасугай.

5.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар, (Н.Батсайхан), Дотоод аудитын газар (Ж.Батхуяг)-т даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН



Монголбанкны Ерөнхийлөгчийн
2016 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн
4-29. дугаар тушаалтын хавсралт

ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмаар Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Улсын Их Хурлын 2016 оны 40 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн Монголбанкнаас банкинд орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэр олгох, түүний нөхцөлийг тодорхойлох, эргэн төлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дараах байдлаар ойлгоно:

- 1.2.1 **“Орон сууцны ипотекийн зээл”** гэж бүрэн баригдаж дууссан, улсын комисс ашиглалтад хүлээн авсан, улсын бүртгэлд бүртгэгдсэн, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээгээр баталгаажсан орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийг;
- 1.2.2 **“Үнэт цаасжуулах”** гэж иргэдэд олгосон орон сууцны ипотекийн зээлийг багцлан, түүнийг барьцаа, баталгаа болгон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааг;
- 1.2.3 **“Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас”** гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан хөрөнгөөр баталгаажсан, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаасыг;
- 1.2.4 **“Орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан бонд”** (цаашид ИЗББ гэх) гэж орон сууцны ипотекийн зээлийг банкны санхүүгийн тайлан тэнцлээс хасч, зээлтэй холбоотой шаардах эрх болон олох орлогыг Тусгай зориулалтын компани (цаашид ТЗК гэх)-ийн санхүүгийн тайлан тэнцэлд шилжүүлэн банкийг хөрөнгөтэй холбоотой үүргээс бүрэн чөлөөлснийг гэрчилсэн баталгаат үнэт цаасыг;
- 1.2.5 **“Тусгай зориулалтын компани”** гэж Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг авсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийг;
- 1.2.6 **“Орон сууцны ипотекийн зээлийн дахин санхүүжилт”** гэж өмнө нь олгосон зээлийг шинэ нөхцөлгэй зээлд шилжүүлэх үйл ажиллагааг;
- 1.2.7 **“Зээл үнэлгээний харьцаа”** (цаашид ЗҮХ гэх) гэж зээлийн дүн, эсхүл зээлийн үлдэгдлийг барьцаа хөрөнгийн үнэлгээнд харьцуулсан хувийг;



ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

- 1.2.8 “Өр, орлогын харьцаа” (цаашид ΘΟХ гэх) гэж өрхийн сард төлөх нийт зээлийн телбөрийг түүний татварын өмнөх орлогод харьцуулсан хувийг;
 - 1.2.9 “Солих нөхцөлгүй хэлцэл” гэж банкнаас зээлийн хөрөнгийн шаардах эрхийг эрсдэлийн хамт ТЗК-д бүрэн шилжүүлэх нөхцөлтэй хэлцлийг;
 - 1.2.10 “Зээлийн багц” гэж нэг удаагийн хэлцлийн үр дүнд банкны худалдаж буй зээлийн хөрөнгийн нийлбэрээс бүрдэх багцыг;
 - 1.2.11 “Малчин өрх” гэж дөрвөн улиралд мал хариулдаг, мал аж ахуйн үйл ажиллагаанаас амьжиргааны үндсэн орлогоо бүрдүүлдэг өрхийг;
 - 1.2.12 “Нийтийн зориулалттай орон сууц” гэж Орон сууц хувьчлах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.3-т заасан барилгыг;
 - 1.2.13 “Амины орон сууц” гэж аймаг, сумын төвийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 21 аймгийн нутаг дэвсгэрт баригдсан, орон сууцны бүх хэсэг нь бие даасан ханаар хүрээлэгдсэн, тусдаа газарт баригдсан орон сууцны зориулалттай сууцыг.
 - 1.3 Энэ журам нь зөвхөн Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлтгэй хүүтэй зээлийн үйл ажиллагааг зохицуулах бөгөөд Монголбанкнаас баталсан орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааг зохицуулах журamtай нийцсэн байна.
 - 1.4 Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтолцоонд оролцогч талуудын эрх, үүрэг, тэдгээрийн хооронд хийгдэх санхүүгийн бүтээгдэхүүний хэлцлийн бүтэц, нөхцөлийг Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Банкууд, МИК ОССК ХХК-ийн хооронд байгуулах Ерөнхий гэрээнд тусгана.
 - 1.5 Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлтгэй хүүтэй зээлийн үйл ажиллагаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг ханган ажиллаж буй банкаар дамжин хэрэгжинэ.
- Хоёр. Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий нөхцөл, шалгуур үзүүлэлт**
- 2.1 Энэ журмын дагуу санхүүжүүлэх орон сууцны ипотекийн зээл нь дараах нөхцөлтэй байна:
 - 2.1.1 Орон сууцны ипотекийн зээлийн хугацаа 360 хүртэл сар;
 - 2.1.2 Орон сууцны ипотекийн зээлийн хүү жилийн 8 хувь;
 - 2.1.3 Зээлийн зориулалт нь орон сууц худалдан авах;
 - 2.1.4 Урьдчилгаа төлбөр 30 хувиас доoshгүй, 3YX 70 хувиас дээшгүй;
 - 2.1.5 ΘΟХ өрхийн татварын өмнөх орлогын 45 хувиас хэтрэхгүй;
 - 2.1.6 Худалдан авах нийтийн зориулалттай орон сууцны талбайн хэмжээ 80m^2 -аас ихгүй;
 - 2.1.7 Зээлийн урьдчилан төлөлт хийх боломжтой байх (гэрээнд тусгаснаар);
 - 2.1.8 Бүрэн хорогдох, тогтмол хүүтэй;
 - 2.1.9 Барьцааны зүйл нь энэ журмын 2.6-д заасан шаардлагыг хангасан.



2.2 Зээл хүсэгч өөрийн өмчлөлд байгаа орон сууцыг барьцаа болгон орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүйтэй зээл авч, зээлээр худалдан авах шинэ орон сууцны урьдчилгаа төлбөрийг төлж болно.

2.3 Нийтийн зориулалттай орон сууцны нийт талбайн хэмжээг “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал” MNS 6058:2009 стандартын дагуу тооцно.

2.4 Энэ журмын 2.1.6-д заасан нийтийн зориулалттай орон сууцны нийт талбайн хязгаарлалтанд журмын 2.2-т заасан урьдчилгаа төлбөрийн орон сууцны ипотекийн зээлийн барьцаа хамаарахгүй.

2.5 Энэ журмын дагуу санхүүжүүлэх орон сууцны ипотекийн зээл хүсэгч дараах шаардлагыг хангасан байна:

- 2.5.1 Монгол улсын иргэн, 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай;
- 2.5.2 Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй;
- 2.5.3 Банк, санхүүгийн байгууллагад Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүйтэй зээлийн өрийн үлдэгдэлгүй. Үүнд хамтран зээлдэгч хамаарна;
- 2.5.4 Шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр, төлбөргүй;
- 2.5.5 Зээлийн хугацаа дуустал холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгалд хамрагдах;
- 2.5.6 Барьцаалбар үлдэх.

2.6 Энэ журмын дагуу санхүүжүүлэх орон сууцны ипотекийн зээлээр худалдан авах орон сууц буюу зээлийн барьцааны зүйл нь дараах шаардлагыг хангасан байна:

- 2.6.1 Монгол Улсад байршилтай нийтийн зориулалттай болон амины орон сууц;
- 2.6.2 Шинээр ашиглалтад оруулсан орон сууцны хувьд инженерийн дэд бүтэц (цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга, холбоо дохиолол)-д бүрэн холбогдсон, эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглалтад хүлээн авсан орон сууц;
- 2.6.3 Ашиглагдаж байгаа орон сууцны хувьд инженерийн дэд бүтэцд бүрэн холбогдсон, барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын шийдвэрээр ашиглахыг хориглоогүй байх;
- 2.6.4 Амины орон сууцны хувьд дэд бүтэц (цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга)-ийн шийдэл бүхий эрх бүхий байгууллагын шийдвэрээр байнгын ашиглалтад шинээр оруулсан, эсхүл барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын шийдвэрээр ашиглахыг хориглоогүй ашиглалтанд байгаа орон сууц байх;
- 2.6.5 Амины орон сууцны газрыг өмчлөх, эзэмших эрх улсын бүртгэлд бүртгэгдсэн байх бөгөөд эзэмших эрхийн хугацаа нь зээлийн хугацаанаас богиногүй байх;
- 2.6.6 Зээлийн хугацаа дуустал холбогдох хууль тогтоомжийн дагуу эд хөрөнгийн даатгалд хамрагдах;
- 2.6.7 Эд хөрөнгө өмчлөх эрхийн талаар гуравдагч этгээдэд шаардах эрх үүссэн бол хэлцлийн талууд зөвшөөрсөн байх.



ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Гурав. Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилт

- 3.1 Монголбанк өөрийн өмчлөлд байгаа ИЗББ-ын үндсэн болон купоны төлберийн эргэн төлөлтийн орлогоор орон сууцны ипотекийн зээлийг санхүүжүүлэх эх үүсвэрийг банкинд олгоно.
- 3.2 Монголбанк банкинд тухайн сард олгох эх үүсвэрийн дээд хэмжээг тогтоох бөгөөд тогтоосон хэмжээг өмнөх сарын сүүлд банк тус бүрт мэдэгдэнэ.
- 3.3 Банк зээл хүсэгчид зээл олгох шийдвэр гаргаж, зээлийн эх үүсвэрийг тухайн зээлдэгчийн дансанд шилжүүлсний дараа орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэр авах хүсэлтээ сар бүрийн хоёр болон дөрөв дэх долоо хоногийн сүүлийн ажлын одор 10:00 цагт багтаан дараах баримт бичгийн бүрдүүлбэртэй Монголбанкинд ирүүлнэ:
 - 3.3.1 Санхүүжилтийн эх үүсвэр хүссэн албан бичиг;
 - 3.3.2 Зээлдэгчийн дансанд зээлийн эх үүсвэрийг шилжүүлсэн гүйлгээний баримтын баталгаажуулсан хуулбар;
 - 3.3.3 Орон сууцны ипотекийн зээлийн эрэлтийн мэдээлэл;
 - 3.3.4 Өмнөх эх үүсвэрээр санхүүжүүлсэн зээлийн мэдээлэл.
- 3.4 Монголбанк энэ журмын 3.3-т заасан баримт бичигт үндэслэн тухайн банкинд орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэр олгоно. Энэ журмын 3.3-т заасан баримт бичгийг банк хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд Монголбанк тухайн банкинд эх үүсвэр олгохгүй бөгөөд үүнээс үүсэх аливаа эрсдэлийг банк хариуцна.
- 3.5 Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн хүсэлтийг энэ журмын 3.3-т заасан баримт бичиг хүлээн авснаас хойш ажлын 3-5 өдрийн дотор шийдвэрлэнэ.
- 3.6 Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэр олгох тохиолдолд банктай санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ байгуулах бөгөөд уг гэрээнд санхүүжилтийн эх үүсвэрийн хүүгийн хувь хэмжээ, эргэн төлөх хугацаа, эргэн төлөх нөхцөл зэргийг тусгана.
- 3.7 Банк орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийг давуу эрхтэй ИЗББ-ыг Монголбанкинд худалдсан эх үүсвэрээр буцаан төлж болно. Давуу эрхтэй ИЗББ-ын үнэлгээ нь ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн үлдэгдэл болон хүүгийн төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд зөрүүг банк Монголбанкин дахь харилцах данснаасаа төлнө.
- 3.8 Банк давуу эрхтэй ИЗББ-ыг худалдах хүсэлтээ албан бичгээр Монголбанкинд ирүүлэх бөгөөд хүсэлтэнд дараах мэдээллийг багтаасан байна:
 - 3.8.1 ИЗББ-ыг гаргасан огноо;
 - 3.8.2 ИЗББ-ын нэрлэсэн үнэ;
 - 3.8.3 ИЗББ-ын купоны хувь хэмжээ;
 - 3.8.4 ИЗББ-ын купон төлөх давтамж;
 - 3.8.5 ИЗББ-ын өгөөжийн хувь;
 - 3.8.6 ИЗББ-ын зээлийн багцын чанарын үзүүлэлт.



3.9 Монголбанк давуу эрхтэй ИЗББ болон түүний баталгаа болж буй орон сууцны ипотекийн зээлийн багцын мэдээллийг шалгасны үндсэн дээр худалдан авах эсэхийг шийдвэрлэнэ.

3.10 Монголбанк банкнаас давуу эрхтэй ИЗББ худалдан авах тохиолдолд дараах мэдээллийг агуулсан худалдах, худалдан авах гэрээг банктай байгуулна:

- 3.10.1 ИЗББ-ын дугаар;
- 3.10.2 ИЗББ-ын нэрлэсэн үнэ;
- 3.10.3 ИЗББ-ын хугацаа;
- 3.10.4 ИЗББ-ын купоны хэмжээ (нэрлэсэн үнээс хувиар илэрхийлсэн);
- 3.10.5 Купон төлөх давтамж;
- 3.10.6 ИЗББ-ын арилжаалах үнэ;
- 3.10.7 ИЗББ-ын дуусах огноо;
- 3.10.8 ИЗББ-ын төлбөр тооцоо хийх огноо;
- 3.10.9 Хуримтлагдсан купон.

3.11 Монголбанк энэ журмын 3.10-т заасан гэрээг банктай 3 хувь байгуулж, ИЗББ-ын өмчлөх эрхийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (цаашид ҮЦТХТ гэх)-д өөрийн өмчлөлд шилжүүлэн авна.

3.12 Монголбанк худалдан авсан давуу эрхтэй ИЗББ-ын эх үүсвэрээр тухайн банкинд өмнө нь олгосон орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийг буцаан төлүүлнэ. Өмнө нь авсан эх үүсвэрийн үлдэгдэлгүй тохиолдолд банкны өөрийн эх үүсвэрийг нөхөн олгоно.

3.13 Банк орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн эргэн төлөх хугацааг сунгах талаар Монголбанкинд хүсэлт гаргаж болно.

3.14 Банк орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийг Монголбанк, банкны хооронд байгуулах санхүүжилтийн гэрээнд тохирсон хугацаанд багтаан төлөөгүйгээс үүсэх эрсдэлийг бүрэн хариуцна.

3.15 Макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учрах, орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдах, орон сууцны үндэс огцом хэлбэлзэл үүсэх нөхцөл байдал үүсч болзошгүй гэж үзсэн тохиолдолд Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийг зогсоох, дахин санхүүжилт хийхийг зогсоох, хугацааг хойшлуулах, эх үүсвэрийн нөхцөлд өөрчлөлт оруулах зэрэг арга хэмжээ авч болно.

Дөрөв. Банкнаас иргэдэд олгох орон сууцны ипотекийн зээл

4.1 Банк энэ журмын 2.1, 2.6-д заасан нөхцөл, шалгуурын дагуу энэ журмын 2.5-д заасан шаардлага хангасан зээл хүсэгчид орон сууцны ипотекийн зээл олгоно.

4.2 Банк зээл хүсэгчид олгох орон сууцны ипотекийн зээлийн шийдвэрийг бие даан гаргах бөгөөд ТЗК-д зээлийн багцыг худалдах хүртэлх хугацаанд зээлийн эрсдэлийг бүрэн хариуцна.



ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

4.3 Банк энэ журмын дагуу олгосон орон сууцны ипотекийн зээлийг ТЗК-д худалдах, ТЗК-иас гаргасан ИЗББ-ыг худалдан авах хэлцэл хийж, орон сууцны ипотекийн зээлийн багцыг ТЗК-д шилжүүлнэ.

4.4 Банк орон сууцны ипотекийн зээлийн барьцааны зүйлийн чанар, ашиглалтын байдал, барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөлтэй холбоотой нэмэлт шаардлага тавих эрхтэй байна.

4.5 Малчин өрх орон нутагт баригдсан, энэ журмын 2.6-д заасан шаардлагыг хангасан орон сууцыг ипотекийн зээлээр худалдан авах тохиолдолд банк дараах хоёр хэлбэрээр ипотекийн зээлийн төлбөрийг төлүүлж болно:

4.5.1 Малчин өрхийн улирлын чанартай жилийн орлогыг банк хадгаламж хэлбэрээр байршуулж, энхүү хадгаламжаас орон сууцны ипотекийн зээлийн төлбөрийг сар бүр төлүүлнэ. Хадгаламжийн үлдэгдэл зээлийн төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд бусад дансны эх үүсвэрээс төлүүлж болно. Банк малчин өрхийн байршуулсан хадгаламжид зах зээлийн нөхцөлөөр хүү төлнө.

4.5.2 Малчин өрхийн улирлын чанартай орлоготой уялдуулан орон сууцны ипотекийн зээлийн төлбөрийг жилд 2, эсхүл 4 удаа тооцож төлүүлж болно.

4.6 Банк өмнө нь олгосон орон сууцны ипотекийн зээлийг энэ журмын дагуу авсан эх үүсвэрээр дахин санхүүжүүлж болох бөгөөд зээлийг дахин санхүүжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

4.6.1 Дахин санхүүжилтийн хэмжээ өмнө нь олгосон орон сууцны ипотекийн зээлийн өрийн үлдэгдлээс ихгүй байна;

4.6.2 Дахин санхүүжилт хүсэгч зээлдэгчийн зээл нь энэ журамд заасан зээлийн нөхцөл, зээлдэгчийн болон барьцаа хөрөнгийн шалгуурыг тус тус хангасан байна.

Тав. Мэдээ, тайлан

5.1 Монголбанк энэ журмын 3.15-д заасан нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор энэ журмын дагуу олгосон орон сууцны ипотекийн зээл болон зээлээр санхүүжүүлсэн орон сууцны талаарх мэдээлэл (өрхийн сарын орлого, ТОХ, зээлдэгчийн ажил эрхлэлтийн байдал, орон сууцны 1м²-ын үнэ, талбайн хэмжээ гэх мэт)-ийг банкнаас тухай бүр гаргуулан авна.

5.2 Шаардлагатай тохиолдолд Монголбанкны хүсэлтийн дагуу банк энэ журмын дагуу олгосон орон сууцны ипотекийн зээлийн мэдээг Монголбанкинд тухай бүр цахим хэлбэрээр болон бичгээр ирүүлнэ.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1 Монголбанк банкинд олгосон орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн зориулалт, ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт тавина.

6.2 Монголбанкаас олгосон орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийг банк зориулалтын дагуу зарцуулаагүй тохиолдолд Монголбанк дараах арга хэмжээ авна:



- 6.2.1 Санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээг цуцалж, эх үүсвэрийг эргэн төлүүлэх арга хэмжээ авна;
 - 6.2.2 Эх үүсвэрийн хүүг түүнийг ашигласан хугацаанд Төв банкны овернант репо санхүүжилтийн хүүгээр тооцож төлүүлнэ;
 - 6.2.3 Тухайн банкинд энэ журмын дагуу дахин эх үүсвэр хуваарилахгүй.
- 6.3 Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийг банк хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд Монголбанк төлөгдөөгүй үлдэгдлээс үндсэн хүүг 20 хувиар нэмэгдүүлсэн хүүг хугацаа хэтрүүлсэн хоногт тооцно.
- 6.4 Банкнаас иргэдэд олгох орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагаа нь энэ журам болон Монголбанкнаас баталсан орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу хэрэгжиж байгаа эсэхэд Монголбанк хяналт тавина.
- 6.5 Банк иргэдэд олгосон орон сууцны ипотекийн зээлийн зориулалт, эргэн төлөлтэд хяналт тавина.
- 6.6 Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

_____ оОо _____

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 70

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ”
БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**М.ЭНХБОЛД**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 19

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030 БАТЛАХ ТУХАЙ

**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн
Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:**

1.“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал баталсантай холбогдуулан доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т үүрэг болгосугай:

1/ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2/Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах;

3/Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын бүтэц, тогтолцоог бий болгох;

4/Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж байх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /А.Бакей/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай” Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 26 дугаар тогтоол, “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод сууринсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД



“БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА” ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН ЗӨВЛӨМЖ

1. Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулах;
- Бодир ус цэвэрлэх байгууламжийн норм дүрэм, стандартыг өөрийн орны онцлогт тохицуулан, олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, шинээр боловсруулах;
- Томоохон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ тендер шалгаруулалтын баримт бичигт технологийн шийдлийг тусгаж боловсруулах, /шаардлагатай тохиолдолд зураг төслийг гурван хэмжээст орчинд бодитоор гүйцэтгэхээр тусгах;
- Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах.

2. Бодир ус цэвэрлэх байгууламжийн техники, технологийг шинэчлэх, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх чиглэлээр:

- Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон, байгальчинд ээлтэй, инновацид сууриссан лаг, тундасыг бүрэн боловсруулах, цэвэрлэсэн усаадахин ашиглах цэвэрлэх байгууламжийн технологийн шийдлийг судалж, сонгон нэвтрүүлэх;
- Хяналт шинжилгээний лаборатори, туршилт судалгааны баазыг бий болгох, алсын зайн удирдлагын системийг нэвтрүүлэх;
- НААҮ-ний салбарын инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл
- байгуулан, үйл ажиллагааг нь зохион байгуулах;

3. Бүтэц, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох чиглэлээр:

- Нийтийн аж ахуйн үйлчилгээ хариуцсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
- Салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, гадаад, дотоодод мэргэшүүлэх, орон нутагт мэргэжилтэй боловсон хүчнийг тогтвортой суурьшилтай ажиллуулах нөхцлөөр хангах.



2016 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 24

УЛААНБААТАР ХОТ



МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОНООС 2016 ОНЫ IУ УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ СЕМИНАР



Хот, орон нутгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын удирдлага болон инженер техникийн ажиллагсдыг бэлтгэх, мэргэжил, мэдлэг, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх мэргэжлийн сургалтыг зохион байгуулаа. Үүнд:

● “НИЙТИЙН АЖ АХҮЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ СУРГАЛТ”

Салбарын байгууллагын дарга, захирал наарт "НИЙТИЙН АЖ АХҮЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ" 2 хоногийн сургалт, хэлэлцүүлгийг 2016 оны 12 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтад орон нутгийн 19 байгууллагын захирал, удирдлага хамрагдаж сургалт амжилттай зохион байгуулагдлаа.

- Аймаг орон нутгийн Нийтийн аж ахуйн байгууллагуудын шинээр томилогдсон дарга удирдах ажилтнуудын уулзалт зөвлөгөөнөөр БХБ-ын сайд Г.Мөнхбаяр, ОСНААБХЗГ-ын дарга О.Лхагвацэдэн, мэргэжилтнүүдтэй уулзалт хийж БХБЯам, салбарын бүтэц зохион байгуулалт, Нийтийн аж ахуйн системд хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн талаар санал солицож БХБ-ын сайд чиглэл өглөө.



- Мөн Барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц нийтийн аж ахуйн бодлогын газрын дарга О.Лхагвацэдэн Нийтийн аж ахуйн салбарын 2016 оны ажлыг дүгнэж, 2017 онд хийх ажлын зорилт гаргалаа.

- Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс Цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тариф шинэчлэн баталсан мэдээлэл, байгууллагуудын санхүүгийн чадавхийг танилцуулж мэдээлэл хийлгээ.






- ТӨВ АЙМГИЙН “ТӨВ ЧАНДМАНЬ” ДЭХГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



Аймаг орон нутгийн Нийтийн аж ахуйн байгууллагууд Төв аймгийн “Төв Чандмань” ДЭХГазрын үйл ажиллагаатай танилцаж, Цэвэрлэх байгууламж, Газрын дулаанаар хэрхэн дулаан хангамжаа шийдсэн, Ухаалаг ус түгээх байрыг хэрхэн барьж ашиглалтад оруулах туршлага судлав.





● НАЙЛАХ ДҮҮРГИЙН ГЭР ЦЭЦЭРЛЭГИЙН УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖТАЙ ТАНИЛЦЛАА



Налайх дүүргийн Гэр хороололд гэр цэцэрлэгийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг хэрхэн шийдвэрлэсэн мөн шинээр байгуулж ашиглалтад оруулсан цэвэрлэх байгууламжтай танилцлаа.





- БАГАНУУР ДҮҮРГИЙН “БАГАНУУР УС” ОНӨҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЙЛ ӨРХИЙН УСНЫ ТООЛУУРЫГ ХЭРХЭН СУУРИЛУУЛСАН, УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



Усны тоолуурын нэгдсэн узель зангиdsанаар айл бүрт PPR хуванцар хоолойгоор босоо шугам шинээр татаж зоорийн давхарт айл бүрийн босоо шугамд халуун хүйтэн усны тоолуур суурилуулсан байна. Энэхүү ажлын үр дүнд нэг айлд 4-5 ш тоолуур суурилуулдаг байсан бол нэгдсэн узельд тоолуур тавьснаар 2 ш тоолуур суурилуулж байна. Мөн айл өрхүүд өөрийн эзэмшил босоо шугамтай болж сантехникийн гэмтэл гараад бусдын хэрэглээг хязгаарлахгүйгээр үйлчилгээ хийх боломжтой болсон. Тоолуурын заалт авах, баталагаажуулахад хэрэглэгчээс хамаарахгүй болсон байна.





● ЦЭВЭР БОХИР УСНЫ МАШИНИСТЫН МЭРГЭЖИЛ ОЛГОХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хот, хөдөөгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын мэргэжилтэй ажиллагсадыг бэлтгэх үүднээс сургалтын төвтэй хамтарч Цэвэр бохир усны машинистын мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж 9 ажилтаныг мэргэжилтэй болголоо.

● “ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ИНЖЕНЕРИЙН ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ” ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Тус сургалтанд орон нутгийн 4 компанийн инженер хамрагдсан бөгөөд сургалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулж мэдлэг олголоо. Сургалтаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, эрх үүрэг, хариуцлага байгууллагын тогтолцоо, хөдөлмөрийн нөхцөл, ослын шалтгаан, байгууллагын ХАБЭА орчныг сайжруулах” зэрэг нийт 40 цагийн сургалтад хамрагдан батламж гардууллаа.



“УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ” ХӨТӨЛБӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ БОЛЛОО

“УАБТ-ний хэрэгжилтийн хүрээнд аудит хийх үндэсний чадавхийг бүрэлдүүлэхийг чухалчилсан цөөн улс орнуудын нэг нь Монгол улс юм.

Иймээс ч ДЭМБ энэ сургалтанд ач холбогдол өгч дэмжиж байна,” гэж ДЭМБ-ын Суурин төлөөлөгч Др Су Нуунт У нийслэл, аймгийн ус хангагч байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагын нийт 65 мэргэжилтэн цугласан сургалтын үйл ажиллагааны нээлтийн үеэр хэлээ. УАБТ-г ДЭМБ, Австралийн засгийн газрын Гадаад харилцаа, худалдааны газраас манай бүсийн улс орнуудад 2009 оноос, Монгол улсад 2012-2016 онуудад нэвтрүүлсэн түүх, ололт амжилтаас ДЭМБ-ын мэргэжилтэн В.Дэлгэрмаа танилцууллаа.

“УАБТ-г боловсруулж, ажил хэрэг болгоход чин сэтгэлээсээ, маш их санаачилга, эрч хүч, хүсэл эрмэлзэл гаргаж ажилласан Монголчууд та бүхнээрээ би баихаж явдаг,” гэж сургалтын багш, ДЭМБ-ын УАБТ зөвлөх, 2014 оноос Монголд ирж УАБТ-г нэвтрүүлэх үйл ажиллагааны зөвлөхөөр ажилласан Жон Дэннис хэллээ. Тэрээр, УАБТ гэдгийн цаана хэрэглэгчдэд өвчин үүсгэгч нянгүй, патогенгенгүй, хүнд металгүй, нэг үгээр хэлбэл, аюулгүй ус хүргэхийг эрхэмлэсэн ажил байдгийг хэлээ. Хуучин тогтолцоо нь ус түгээлтийг л анхаардаг байсан бол УАБТ гаргаж ажилласнаар ниймгийн эрүүл мэндийг ус түгээлтийн тогтолцоонд анхаарч ажиллах бололцоотой болж байгааг зөвлөх Дэннис тайлбарлав. Ийнхүү олон салбар хоорондын хамтын ажиллагааг шаардсан ундны усны аюулгүй байдлыг Монгол орны аль ч өнцөг буланд хангах том ажил амжилттай өрнөж байна.



"Усны аюулгүй байдлын төлөвлөгөө" хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах үндэсний зөвлөлдөх уулзалт 11-р сарын 30-ны өдөр Тушин зочид буудалд боллоо. Ойролцоогоор 150 мэргэжилтэн бүхий олон салбарын төлөөлөлт хүрэлцэн ирсэн энэ уулзалтын үеэр ДЭМБ-аас дэмжин Монгол улсад хэрэгжүүлж буй Усны аюулгүй байдлын төлөвлөгөө хөтөлбөр нь бусад улс орнуудаас хожуу эхэлсэн боловч маш амжилттай хэрэгжиж 21 аймаг бүр өөрийн төлөвлөгөөтэй болсныг онцлон тэмдэглэж байв.

ДЭМБ-ын Суурин төлөөлөгч Др Су Нуунт У:

"Амжилт их байгаагийн хажуугаар хийх зүйл ч их байна. Дөрвөн жилийн энэ ажил бол зөвхөн гарaa, эхлэл. Цаашдаа сум болгон өөрийн усны аюулгүй байдлын төлөвлөгөөтэй болж ажиллах хэрэгтэй" гэлээ.



Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн:

"Үндны усны аюулгүй байдлыг хангахын тулд усны эх үүсвэрээс хэрэглэгч хүртэлх бүх цэгүүдэд ус бохирдуулах хүчин зүйлсийг тогтоож, эрсдлийг үнэлэх, бохирдоос урьдчилан сэргийлэх үүднээс 2012 оноос эхлэн ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хот суурин газрын 2 ус хангагч байгууллага, жижиг суурин газрын 6 байгууллагуудад "Усны аюулгүй байдал" хөтөлбөрийг нэвтрүүлснээр өнөөдрийн байдлаар хот суурин газрын 22 ус хангагч байгууллага (нийслэл, 21 аймгийн ус хангагч байгууллага), жижиг суурин газрын 23 байгууллага болж өргөжиж 1 сая 900 гаруй хүн ам уг төлөвлөгөөний үр ашгийг хүртээд байна" гэлээ.

ЭМЯ, ДЭМБ, УСУГ зэрэг байгууллагуудаас хамран УАБТ дээр 4 жилийн турш амжилттай хамтран ажилласан 8 хамт олонд Өргөмжлөл гардууллаа. Мөн ДЭМБ-ын Суурин төлөөлөгч Др Су Нуунт У-г Эрүүл мэндийн салбарын хүндэт тэмдэгээр ЭМЯ шагнаалаа.






МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2017 ОНЫ ГУЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ СЕМИНАР

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооноос 2017 онд зохион байгуулах дотоод сургалт семинарын төлөвлөгөөний дагуу салбарын байгууллагуудын удирдлага болон инженер техникийн ажиллагсдыг бэлтгэх, мэргэжил, мэдлэг, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх мэргэжлийн сургалтыг зохион байгуулаа. **Үүнд:**

- ЭДИЙН ЗАСАГЧ, НЯГТЛАН БОДОГЧДЫГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ

Тус сургалт энэ оны 1 сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад нийт 19 байгууллагын эдийн засагч, нягтлан бодогч хамрагдсан бөгөөд байгууллагын стратеги зорилт, бизнес төлөвлөгөө, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах арга зүй, усны үнэ тариф тооцох аргачлал зэрэг нийт 32 цагийн сургалт явагдаж амжилттай өндөрлөлөө.

Мөн ОСНААУГ-ын Дуудлагын нэгдсэн системийн үйл ажиллагаатай танилцаж, Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн орон нутаг хариуцсан мэргэжилтнүүдээсээ мэдээллийн системийн талаар зөвлөгөө авлаа.





**● ШУГАМ ХООЛОЙ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧНЫ
МЭРГЭЖИЛ ОЛГОХ СУРГАЛТ**

Хот, хөдөөгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын мэргэжилтэй ажиллагсадыг бэлтгэх үүднээс сургалтын төвтэй хамтарч Шугам хоолой, тоног төхөөрөмжийн засварчны мэргэжил олгох 14 хоногийн сургалт 01 сарын 23-аас 02 сарын 03 өдрүүдэд зохион байгуулагдаж 6 засварчин мэргэжилтэй боллоо.



**● ЦЭВЭР, БОХИР УСНЫ ЛАБОРАТОРИЙН АЖИЛТНЫГ
ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ**

Монгол Улсын Их Хурлын 2008.01.31-ний өдрийн 13 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтын хавсралтыг шинэчлэн баталж, “2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах” зорилт дэвшүүлсэн билээ.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт аймгууд, томоохон суурин газруудын нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудыг цэвэр, бохир усны суурин болон зөөврийн лабораторитой болгох ажлын эхний үе шат хэрэгжиж лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж ашиглалтанд орсон.

Үүнтэй холбоотой цэвэр, бохир усны суурин болон зөөврийн лабораторийн тоног төхөөрөмжийг хэвийн найдвартай ажиллуулах, ажилчдыг дадлагажуулж мэргэшүүлэх үүднээс лабораторийн ажилчдад 2 сарын 13-17-ны хооронд чадавхижуулах сургалт явуулсан бөгөөд 4 ажилтан хамрагдаж сургалт амжилттай өндөрлөлөө.





БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯМ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ДЭД САЙД Ш.ЛХАМСҮРЭН

БОХИР УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД



- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай
- Барилгын тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Эрүүл ахуйн тухай хууль
- Эрүүл ахуйн тухай хууль

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

- ✓ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /УИХ-ын 2016 оны 19 дугаар тогтоол/
- ✓ Төрөөс экологийн талаар баримтлах бодлого /УИХ-ын 1997 оны 107 дугаар тогтоол/
- “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр /УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол/
- ✓ “Ус” үндэсний хөтөлбөр /УИХ-ын 2010 оны 24 дугаар тогтоол/
- ✓ Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- ✓ “Ногоон хөгжлийн бодлого” /УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол/

НҮБ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ 2030 ХӨТӨЛБӨРҮҮН 6-Р ЗОРИЛТ



Цэвэр ус, ариун цэврийн байгууламж

Бүх нийтийг баталгаат ундны ус, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байх боломжоор хангах, ус, ариун цэврийн тогтвортой менежменттэй болох

2030 гэхэд шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, эрүүл эрүүл ахуйн нөхцөлөөр бүх нийтээрээ эрх тэгш хангагдаж, ил задгай бие засах байдлыг таслан зогсоож, охид эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага, үүнтэй холбоотой эмзэг нөхцөл





**Монгол улсын тогтвортой хөгжлийн
үзэл баримтлал - 2030**

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ye шат I: 2016-2020

Ye шат II: 2021-2025

Ye шат III: 2026-2030

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ – 14 чиглэл, 44 зорилт

Эдийн засгийн тогтвортой хөгжил

- Хөдөө аж ахуй,
- Аялал жуулчлал
- Эрчим хүч,
- Зам тээвэр,
- Уул уурхай,
- Аж үйлдвэр,
- Мэдээлэл, харилцаа холбоо

Нийгмийн тогтвортой хөгжил

- Хүртээмжтэй ёсөлт, ядуурал, Боловсрол,
- Эрүүл мэнд, Нийгмийн хамгаалал

Байгаль орчны тогтвортой хөгжил

- Усны нөөцийн менежмент,
- Ур амьсгалын өөрчлөлтэд дасан зохицох,
- Хүлэмжийн хийг бууруулах
- Экосистемийн тэнцвэрт байдал

Тогтвортой хөгжлийн засаглал

- Бизнес эрхлэх орчинг сайжруулах;
- Татварын тогтвортой орчныг бүрдүүлэх;
- Гадаад, дотоодын хөренгө оруулалтын тэшп байдлыг хангаж, таатай орчинг бүрдүүлэх

Ногоон хөгжлийн бодлого

Ногоон хөгжлийн үндсийг тавих үе,
2014-2020 он

Ногоон хөгжилд шилжих үе,
2021-2030 он

1. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ.

6. Ур амьсгалын өөрчлөлт, бус нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.

2. Байгаль орчныг хамгаалах, нехэн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

5. Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инноваций ногоон хөгжлийн хурдасгуур болгоно.

3. Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

4. Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.



БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Улаанбаатар хот

Улаанбаатар хотын ус цэвэрлэх төв байгууламж
Байгуулагдсан он : 1964 онд
Зураг төсөл: ЗХҮ
Хүчин чадал: Хоногт 45000 м3
Өргөтгөл: 1979, 1986 онуудад хоногт 230000м3 ахуйн бохир ус хүлээн авч 90-92% хүртэл цэвэршүүлэх

Дархан	Архангай, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өмнөговь Сэлэнгэ, Говь-сүмбэр	Булган, Баян - Өлгий, Дорнговь, Дорнод, Увс, Ховд, Хэнтий, Эрдэнэтэд	Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Төв, Хөтөл, Зүүнхараа, Баруунхараа, Бор-Өндөр
1965	1971-1977	1980-1990	1990-ээд оноос хойш

Гадаадын хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод



1998-1999 Түүл голын бохирдолыг бууруулах төсөл 4ш насос суурилуулсан.

2000-2001 Түүл 21 төслөөр хүлээн авч буй усыг хэмжигч багаж, мониторинг системийн хамт байгуулсан.

Испани улсын засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Аэротенкт агаараар хувиарлах систем болон бусад системүүдийг 2 ўе шаттай төсөл

2009 онд БНСУлын DOOHAP компаний UV/Air хэт ягаан түяагаар халдвартгүйжүүлэх байгууламж ашиглалтанд оруулсан.




Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод



2013-2014

Улаанбаатар хотын Багануур дүүргийн, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Нисэхийн 2000 м³-ын хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр ашиглалтад оруулсан.



2013

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн биоцөөрөм, 2-р тунгаагур тус бүр 2-ыг шинээр, Улаанбаатар хотын Багахантай дүүрэгт хоногт 3250 м³ бохир усыг цэвэрлэх байгууламжийг барьж байна.



2017

Хөгжлийн банкны санхүүжилтээр Баянт-Ухаа орон сууцны хорооллын 20000 м³ бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулна.

Хөгжлийн банкны санхүүжилтээр Улаанбаатар хотод





**ЭРДЭНЭТ ХОТЫН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН
ОРГОТГӨЛ 24 000 м³/хоног**



1. Бохир ус хүлээн авах насосны станц

2. Элс баригч

3. Анхдагч тунгаагур

4. Агаар өгөх компрессорын станц

5. Хойрдогч тунгаагур

6. Аеротенк, латийн насосны станц

7. Лаг ётөрүүлэгч

8. Лаг угийжулэх байгууламж

9. Ус хэмжгичийн байр

10. ЦРП-6 дэд станц

11. Техникийн шугам холой

12. Гадна дулаан

13. Ус хангамж ариутгах татуурга
аянга хамгаалагч
14. Гадна гэрэлтүүлэг, хүчтэй төхөөрөмж,
15. Хянайлт удирдлагын байр
16. Цахилгааны дэд станц



Санхүүжүүлэгч :	АХБ	АХБ	2002-2008
Хугацаа:	1998 -2002	МОН 1907	МОН 1907
Төслийн код:	МОН 1560	Архангай, Дорнод, Дорноговь, Дундговь,	Архангай, Дорнод, Дорноговь, Дундговь,
Хэрэгжсэн газар:	Хөвсгөл, Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд,	Хөнгөнгөвь, Сүхбаатар	Хөнгөнгөвь, Сүхбаатар
Санхүүжилтийн хэмжээ:	5564.74 сая.төгрөг	Санхүүжилтийн хэмжээ:	17874.75 сая.төгрөг



АХБ-ны хөнгөлөлттэй буцалгүй туслахжаар	БНХАУ-ЫН Засгийн газрын хөнгөлөлттэй зээл	НҮБХХ, АХБ хөнгөлөлттэй зээл	АХБ-ны зээл	АХБ-ны хөнгөлөлттэй зээл
Баянхонгор, Говь-Алтай аймгийн төв, Эмнэговь, Гурван Тэст 100 м ³ , Ханбогд суманд 600м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг гшинээр барьж, 2017 онд ашиглалтад оруулна.	Орхон аймгийн Эрдэнэт хотод хоногт 24000 м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг гшинээр барьж, 2017 онд ашиглалтад оруулна.	Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 3200 м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг инженерийн шугам сүлжээний хамт шинээр барьсан.	Төв аймгийн Зуунмод сум, Зуундэлгэр баатарын Гурван сайхан, Булган аймгийн Бүрэгхангай, Тэшиг, Оврөхангай аймгийн Баянгол, Сант нийт 8 суманд инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглалтад оруулаад байна.	Дархан хотын бохир усны менежментийн МОН 3244/3245 төслийн хүрээнд хоногт 20000 м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барилгын төслийг 2016-2019 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр бэлтгэл ханганд ажиллаж байна.
Баянхонгор, Говь-Алтай аймгийн төв, Эмнэговь, Гурван Тэст 100 м ³ , Ханбогд суманд 600м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг инженерийн шугам сүлжээний хамт барьж ашиглалтад орууласан.	Орхон аймгийн Эрдэнэт хотод хоногт 24000 м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг гшинээр барьж, 2017 онд ашиглалтад оруулна.	Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 3200 м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг инженерийн шугам сүлжээний хамт шинээр барьсан.	Төв аймгийн Зуунмод сум, Зуундэлгэр баатарын Гурван сайхан, Булган аймгийн Бүрэгхангай, Тэшиг, Оврөхангай аймгийн Баянгол, Сант нийт 8 суманд инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглалтад оруулаад байна.	Өмнөговь, Архангай аймгийн төвд хоногт 3000 м ³ , Дорноговь аймгийн төвд 4200 м ³ бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барилгын төслийг 2017 оноос эхлэн хэрэгжүүлэхээр бэлтгэл ханганд ажиллаж байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт



Төв аймгийн Зуунмод, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум
2015 онд

“Сумын төсвийн шинчлэл” төслийн хүрээнд 8 аймгийн 8 суманд 50-250 м³/хоногийн хувчин чадал бүхий цэвэрлэх байгууламжийг шинээр ашиглалтад оруулсан.




2016 онд
Хөгжлийн банкны санхүүжилтээр Ховд аймгийн Жаргалант суманд хоногт 4200 м³ бохир усыг цэвэршүүлэх цэвэрлэх байгууламжийг өргөтгэн шинчилж, ашиглалтад оруулсан.




Хоногт 50, 100, 150, 250, 3000 м³ бохир ус цэвэрлэх байгууламжийн нэг маягийн зураг төсөл болон Архангай, Булган, Дорноговь, СэлэнгийнХөтөл, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий аймгийн төв, Дархан-Үүл аймгийн Шарын гол сумын бохир ус цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулан магадлал хийлгэн баталгаажуулсан.

Өргөтгэн шинчилсэн болон шинээр барьсан бохир ус цэвэрлэх байгууламжийн тоо




Сүүлийн 5 жил баригдаж,
ашиглалтанд орсон цэвэрлэх
байгууламжийн тоо

Ус хангамж, ариун цэврийн
байгууламжийн хүртээмж



Ариун цэврийн байгууламжийн хүртээмж





БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯМ

ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛСҮҮД

Барилга,
байгууламжийн
хийц, бүтээцийн
эвдрэл гэмтэл

Тоног
төхөөрөмжийн
ашиглалтын
хугацаа дуусаж
хуучирсан

**Дотоод хүчин
зүйлс**

Мэргэжилтэй
боловсон хүчин
дутмаг

Их, урсгал засврыг
тогтоосон
хугацаанд
гүйцэтгэдэггүй

Санхүүгийн
чадамж сул

Гадаад хүчин зүйлс



Эрүүл мэндийн байгууллагуудын
шингэн хог хаягдлыг төвлөрсөн шугамд
шууд нийлүүлжбайгаа нь эмгэг төрөгч
нян, вирусээр орчныг бохирдуулах
нөхцлийг бүрдүүлж байна.

Арьс шир, ноос ноолуурын үйлдвэрийн
цэвэрлэх байгууламжийн техник
технологийн хүчин чадлаас хамаарч
стандартын шаардлагын хэмжээнд
хүртэл цэвэрлэжчадахгүй төвлөрсөн
шугам сүлжээнд нийлүүлжбайгаа нь
бохир ус цэвэрлэх байгууламжийн
цэвэрлэгээний түвшинд нөлөөлж
байна.



ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ТӨСӨӨЛӨЛ

Хууль эрх зүйн орчны хүрээнд

1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын механизмыг боловсронгуй болгох.

2. “Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандарт,

“Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015 шаардлага стандартуудыг мөрдүүлэх.

3. Бохир ус цэвэрлэх байгууламжийн норм, стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах.

4. Салбар дундын ажлын уялдаа холбоог сайжруулах, хувийн хэвшилд дэмжлэг үзүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх.

Төсөл, хөтөлбөрийн хүрээнд

Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах.

ҮИХ-ын тогтоолоор батлагдан гарсан “Ногоон хөгжлийн бодлого”, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Бохир ус цэвэрлэх байгууламжийн техник, технологийг шинэчлэх, шинэ дэвшилтэй технологийг нэвтрүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

Цэвэрлэх байгууламжийн чиглэлээр хийгдсэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтад нэгдсэн аудит, дүн шинжилгээ хийлгэх, өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах



БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯМ

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ, ТӨСӨӨЛӨЛ

Судалгаа шинжилгээ, зураг төсөл боловсруулах, төлөвлөх хүрээнд

Судалгаа шинжилгээний хүрээнд

Монгол орны нөхцөлд тохирсон бага хүчин чадлын цэвэрлэх байгууламжийн технологийг судлах, турших эрдэм шинжилгээний судалгаа, туршилтын үр дүнд нэвтрүүлэх ажлыг салбарын түвшинд зохион байгуулах.

Зураг төсөл боловсруулах, төлөвлөх хүрээнд

1. Лагийг боловсруулах, дахин ашиглах механизмыг боловсронгуй болгох,
2. “Ахуйн бохир ус цэвэрлэх зориулалтаар бага хүчин чадлын цэвэрлэх байгууламж ашиглах техникийн ерөнхий шаардлага” ашиглалтын заавар боловсруулж мөрдүүлэх
3. Импортоор орж ирж буй бохир ус цэвэрлэх байгууламжийн техник, технологийг Гааль болон НӨАТ-аас хөнгөлөх арга хэмжээг зохион байгуулах.

Ашиглалтын байгууллагын эрх үүрэг, хүний нөөцийг чадавхижуулах, хяналт шинжилгээний ажлын хүрээнд

Ашиглалтын байгууллагын эрх үүргийн хүрээнд:

Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, цэвэрлэгээний түвшинг дээшлүүлэхэд орон нутгийн түвшинд дэмжлэг үзүүлэх.

Бохир усны хяналт шинжилгээний лабораторийг бэхжүүлэх.

Хяналт шинжилгээний хүрээнд

“Бохир усны шинжилгээний лабораторийн жишиг дүрэм”-ийг боловсруулж, мөрдүүлэх.

Орон нутагт зөөврийн болон суурин хяналт шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх.

Хүний нөөцийг чадавхижуулах ажлын хүрээнд

Мэргэжилтэй боловсон хүчнийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулж дадлагажуулах.

Аймаг, сумын түвшинд мэргэжилтэй ажилтан бэлтгэх туршлага судлах бүсчилсэн сургалт зохион байгуулах.



ЦУВРАЛ 3

**ҮНДНЫ УСЫГ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХЭД НАТРИЙН
ГИПОХЛОРИТЫН УУСМАЛ ХЭРЭГЛЭХ ТЕХНИКИЙН БОЛОН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР**

Зорилго: Үндны усыг натрийн гипохлоритын уусмалаар халдвартгүйжүүлэх аргачлалыг энэхүү заавраар зааж өгнө.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.6. Натрийн гипохлоритын уусмалаар үндны усыг халдвартгүйжүүлэхэд энэхүү зааврыг мөрдөнө.
- 1.7. Натрийн гипохлоритын уусмалаар халдвартгүйжүүлэх үеийн аюулгүй ажиллагааг мөрдөхөд энэхүү зааврыг ашиглана.
- 1.8. Ус хангамжийн байгууллагын эх үүсвэрийн усыг натрийн гипохлоритын уусмалаар халдвартгүйжүүлэх ажиллагааг ус хангамжийн байгууллагын халдвартгүйжүүлэлт хариуцсан ажилтнууд хариуцан гүйцэтгэнэ.
- 1.9. Үйлдвэрийн натрийн гипохлоритын уусмалын идэвхийг тодорхойлох ажлыг Ус хангамжийн байгууллагын дотоодын хяналтын лабораторийн мэргэжилтнүүд хариуцан гүйцэтгэнэ.
- 1.10. Натрийн гипохлоритын уусмалын идэвхит хлорын агууламжийг улиралд нэгээс доошгүй удаа дотоодын хяналтын лабораториор хянуулж баталгаажуулсан байна.

Хоёр. Халдвартгүйжүүлэх ажлын явц, дараалал

- 2.2. Үндны усыг натрийн гипохлоритын уусмалаар халдвартгүйжүүлэхийн өмнө дараах бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:
 - 2.2.1. Зөвхөн үндны усны халдвартгүйжүүлэлтэнд хэрэглэхийг зөвшөөрсөн 10 – 18 % – ийн идэвхитэй хлор агуулсан натрийн гипохлоритыг хэрэглэнэ.
 - 2.2.2. Халдвартгүйжүүлэлтэнд хэрэглэх бодисыг худалдан авах, хадгалах чиглэлээр гаргасан тусгай зааврын дагуу халдвартгүйжүүлэлтэнд хэрэглэх натрийн гипохлоритыг худалдан авч, зааврын дагуу хадгална.
- 2.4. Үндны усыг натрийн гипохлоритын уусмалаар халдвартгүйжүүлэх
 - 2.4.1. Натрийн гипохлоритын уусмалаар халдвартгүйжүүлэхэд тохиромжтой тусгай тунлах төхөөрөмж ашиглана.
 - 2.4.2. Тунлах төхөөрөмжийн тохиргоог халдвартгүйжүүлж буй усны чанар, натрийн гипохлоритын уусмалын идэвхи, усны урсгалын хурд зэргийг харгалзан үйлдвэрлэгчийн гарын авлагын дагуу хийнэ.
 - 2.4.3. Халдвартгүйжүүлэлтийн дараах үлдэгдэл чөлөөт хлорын агууламжийг станцын машинист зааврын дагуу цаг тутамд тодорхойлж, Хүснэгт - 1 маягтын дагуу бүртгэл хөтөлж, үлдэгдэл чөлөөт хлорын агууламжийн дундажийг хоног, сараар тус тус гаргана.
 - 2.4.4. Үлдэгдэл чөлөөт хлорын агууламжийг тодорхойлох аргачлалын сургалтанд хамрагдаж чадамжийн гэрчилгээтэй болсон машинист халдвартгүйжүүлэлтийн дараах үлдэгдэл чөлөөт хлорын агууламжийг хянана.
 - 2.4.5. Ус хангамжийн байгууллагын дотоодын хяналтын лаборатори нь халдвартгүйжүүлэлтийн дараах үлдэгдэл чөлөөт хлорын агууламжийг хяналтын сорьц авах бүрд шалган бүртгэл хөтөлсөн байна.



2.4.6. Ээлж өгч буй ажилтан нь тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тоноглол хэрэгсэлүүдийн ажиллагааны байдал, эвдрэл гэмтэл гарч ослын байдалд хүргэж болзошгүй онцгой анхаарах тоног төхөөрөмж, тоноглол, хэрэгсэл, засварт болон нөөцөнд байгаа тоноглолуудын талаар рапортын дэвтэрт Ус хангамжийн байгууллагын дотоодын хяналтын лаборатори нь халдвартгүйжүүлэлтийн үр дүнг хянах зорилгоор халдвартгүйжүүлээд гаргаж буй усан дахь нийт нянгийн тоог хуваарийн дагуу хянаж баталгаажуулан, шинжилгээний дүнг станц дээр байршуулсан байна.

2.4.7. Халдвартгүйжүүлэлтийн дараах усан дахь үлдэгдэл чөлөөт хлорын хэмжээ болон нян судлалын үзүүлэлт нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдэж буй ундны усны чанар, аюулгүй байдлын шаардлагын стандартад заасан хэмжээнээс ихгүй байна.

2.4.8. Ус хангамжийн байгууллагын дотоодын хяналтын лаборатори нь натрийн гипохлоритын уусмалын идэвхийг улиралд нэгээс доошгүй удаа тодорхойлж шинжилгээний дүнг станц дээр байршуулсан байна.

Гурав. Ээлж хүлээлцэх

3.8. Ээлж хүлээлцэхдээ хлорын слесарь, операторчин, засварчид ээлж хүлээлцэх дэвтэр, рапорт болон бусад бичиг баримттай сайтар танилцана.

3.9. Нэг бүрийн багажнууд, бичиг баримтуудыг сайтар үзэж шалгаж хүлээж авна.

3.10. Тунлах төхөөрөмжийн ажиллагаа, холбооны хэрэгсэлийн бүрэн бүтэн байдлыг шалгана.

3.11. тэмдэглэж хүлээн авч буй ажилтанд танилцуулах бөгөөд натрийн гипохлоритын уусмалын хэмжээ, үлдэгдэл чөлөөт хлорын агууламжийн талаар мэдээлэл солилцож, Хүснэгт - 2 маягтын дагуу бүртгэл хөтлөн гарын үсэг зурсан байна.

3.12. Хүлээлцэх явцад тунлах төхөөрөмжинд бага зэргийн догоодол, гэмтэл илэрвэл газар дээр нь засаж, үүнийг рапортын дэвтэрт бичнэ.

3.13. Хлоржуулах байгууламжид ариун цэврийг сайтар сахих шаардлагатай бөгөөд ажлын байр, тоног төхөөрөмжийг бүрэн цэвэрлэж хүлээлгэж өгнө.

3.14. Ээлжинд ажиллахын өмнө тунлах төхөөрөмжийг ажиллуулах заавартай сайтар танилцсан байх шаардлагатай.

Дөрөв. Аюулгүй ажиллагааны зааварчилга

4.6. Энэхүү зааврыг натрийн гипохлоритын уусмалаар ундны усыг хлоржуулдаг байгууламжийн бүх ажилтнууд нэгэн адил дагаж мөрдөнө.

4.7. Ажилтанг хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй /ХАБЭА/-н сургалтанд хамруулж, шалгалах авч, бие даан ажиллах чадвар дадлага сурсан нөхцөлд ажиллахыг зөвшөөрнө.

4.8. Аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэрт зааварчилгаа өгсөн, авсан тухай тэмдэглэлийг хөтөлж гарын үсэг зурсан байна.

4.9. Агууламж өндөртэй натрийн гипохлориттой харьцахдаа бээлий өмсөж, нүдний шил зүүх шаардлагатай.

4.10. Натрийн гипохлоритын уусмалыг хадгалж буй саванд хаягжуулалт хийж, агууламжийг нь тэмдэглэсэн байх бөгөөд хадгалж буй газрыг битүүмжилж цоожилсон байна.



Хүснэгт 1. Үлдэгдэл чөлөөт хлорын агууламжийг бүртгэх бүртгэлийн маягт

Станцын нэр:

..... он сар өдөр

Шинжилгээ хийсэн цаг	Сорьц авсан цэг	Үлдэгдэл чөлөөт хлорын тооцоо				Шинжилгээ хийсэн ажилтны гарын үсэг	Тайлбар	
		Зарцуулагдсан натрийн тиосульфатын хэмжээ, мл	Засварын коэффициент	Үлдэгдэл чөлөөт хлорын агууламж, мг/л				
24 ЦАГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, МГ/Л								

БҮРТГЭЛИЙГ ХЯНАСАН:

СТАНЦЫН ИНЖЕНЕР /гарын үсгийн тайлал/
гарын үсэгЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ /гарын үсгийн тайлал/
гарын үсэг

Хүснэгт 2. Ээлж хүлээлцэх бүртгэлийн маягт

Cap, өдөр	Цаг	Натрийн гипохлоритын уусмал		Үлдэгдэл чөлөөт хлорын агууламж, мг/л	Гарын үсэг	
		Зарцуулсан хэмжээ, литр	Үлдэгдэл хэмжээ, литр		Ээлж хүлээлгэн өгсөн	Ээлж хүлээн авсан
Сарын дүн						

БҮРТГЭЛИЙГ ХЯНАСАН: СТАНЦЫН ИНЖЕНЕР /гарын үсгийн тайлал/

Нийтлэлийг гаргасан: УСУГ-ын Сургалтын төвийн багш, УАБТ-ний сургагч багш, үндэсний зөвлөх С.Бумаа

УСУГ-ын Усны төв лабораторийн судалгааны ажилтан, УАБТ-ний сургагч багш, үндэсний зөвлөх Б.Урнаа

Үргэлжлэлийг дараагийн дугаарт



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай компани 2004 онд байгуулагдан 2004-2013 оны хооронд орон сууцны барилгын ашиглалт үйлчилгээ, цахилгаан, сантехникийн магистраль шугам сүлжээ, инженерийн тоног төхөөрөмжийн угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэн 2014 оноос шинэ технологи_менежментээр ажиллаж байна.



Манай хамт олон «ДЭД БҮТЭЦ_УХААЛАГ ШИЙДЭЛ» төслийн хүрээнд НААУ-ний салбарт төсөл хэрэгжүүлээд байна.

Энэхүү төслийн зорилго: «АРЗАМАС» хэмжих хэрэгсэл, «СТРИЖ» мэдээллийн систем нь ОХУлс болон БНКазахстан Улсын хэд хэдэн хотуудад хэрэгжүүлж, олон улсын чанарын шаардлага стандартын хувьд монголын зах



зээлд нийцэх шилдэг шинэ технологийн бүтээгдэхүүн гэдэг нь нотлогдсон тул өнөөдөр бид хэрэглэгч аж ахуй нэгж байгууллага, айл өрх, иргэдийн сэтгэлд нийцсэн, тэдний шаардлагыг хангасан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх зарчмыг баримтлан тэдний эрэлт хэрэгцээ, ашиг сонирхолд нийцсэн, шинэ технологи бүхий бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэвшилтэг технологи цогц үйлчилгээ үзүүлэх зорилт тавин хэмжих хэрэгслийн үйлчилгээний лабораторийн төв байгуулан 24 цагийн турш дуудлагат засвар үйлчилгээ болон шинэ технологи болох мэдээллийн системийн хянах ажиллагааг нэвтрүүлэх, өргөжүүлэх цогц шийдэлд хүргэхээр бэлтгэл ажил хангагдан ажиллаж байна.

ОХУ-ЫН "АРЗАМАССКИЙ ПРИБОРОСТРОЙТЕЛЬНЫЙ ЗАВОД ИМЕНИ П.И.ПЛАНДИНА"
Манай компани дараах судалгаа, шинжилгээний үндсэн дээр 2014 онд "АПЗ" үйлдвэртэй гэрээ байгуулж,

Монгол дахь албан ёсны гэрээт борлуулагчаар ажиллаж байна.



Улаанбаатар хотын хүн амын өсөлт болон хүн амыг орон сууцаар хангах хөтөлбөртэй уялдан усны хэрэглээ нэмэгдэж, үндны усны үндсэн эх үүсвэр болсон Туул голын сав газрын гүний усны нөөц багасч байгаа нь энэ цаг үеийнхийн сэтгэл эмзэглүүлсэн асуудлын нэг болоод байна. Дэлхийн цаг агаарын дулаарал, хүмүүсийн хүрээлэн буй орчинтой зүй бусаар харьцах явдал, үндны усны эх үүсвэрийн бохирдол, орон сууцны оршин суутчдын үр ашигтүй хэрэглээ зэрэг нь хот суурин газрынханд усны усиг хайр гамтай хэрэглэх цаг ирснийг сануулах болов.

Усны зохицтой хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн «Ус үндэсний хөтөлбөр»-ийн хүрээнд ус тоолууржуулах ажил идэвхитэй явагдсан ч сүүлийн жилүүдэд саармагжаад байна. Иймээс хэрэглэгч бүхэн усны үнэ цэнэ, ус хэмнэхийн ач холбогдлыг мэдрэх, усаа хайр гамтай хэрэглэх шаардлагатай болоод байна. Орон сууцны айл өрхийг тоолууржуулах замаар Нийслэлийн үндны усны нөөцийг хамгаалах, усны зохицтой хэрэглээг төлөв шүүлэх, айл өрхийн санхүүгийн үр ашигтүй зардлыг бууруулахад оршино. Ийм цаг үед хүн амын үндны нийлүүлэлт түгээлт, усны тоолуур нийлүүлэх суурилуулах ажлыг аж ахуйн нэгжүүд ямар хэмжээнд хийж байгаа, үүнд хэрхэн анхаарал тавьдаг болохыг бид юуны өмнө эрэл хайгуул хийж судалсан билээ.

ЯАГААД АРЗАМАС-ЫГ СОНГОХ БОЛОВ.

✓ «АПЗ» үйлдвэр нь 1957 онд байгуулагдан, одоо цэргийн болон иргэний гэсэн 2 ангилалаар үйлдвэрлэл явуулдаг. Үйлдвэрийн 21 хувь ОХУ-ын төрийн мэдэлд байдаг. Байгууллагын СТО 513-4.10-07-2013, СТО 513-4.17-02-2014 олон улсын ISO 9001:2010, ISO/IEC 17025:2007 стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

✓ 1998 онд усны тоолуурын лаборатороо нээсэн. ОХУ-ын Техник зохицуулалт, хэмжил зүйн агентлагаас олгогддог туршилын лабораторийн итгэмжлэлийн үйлчилгээ эзэмшидэг.

✓ Усны тоолуур шалгах, загвар турших байгууллагын 4 стандарттай. (ЛГФИ 407223,003 МИ СКВ загварын халуун хүйтэн усны тоолуур шалгах арга аргачлалын стандарт)

✓ Тус үйлдвэрт үйлдвэрлэгдсэн усны тоолуурыг ОХУ-ын Техник зохицуулалт, хэмжил зүйн агентлаг баталгаажуулж үйлчилгээ олгодог.

✓ Үйлдвэрт ОХУ-ын Техник зохицуулалт, хэмжил зүйн агентлаг жил бүр нэгж дамжуулалт хийгддэг. Шалгалт:

- Үйлдвэрлэлийн явцын шалгалт;
- Техник хяналтын товчоонос хийх хяналт;
- Хэмжил зүйн улсын шалгагчын хяналт гэсэн турван хэсгээс бүрддэг.

Өнөөдөр олон улсын хэмжээнд ашиглагдаж буй шинэ техник технологи бүхий ус хэмжигч хэрэгсэлүүдийг Монгол Улсын стандарт нормын дагуу нэвтрүүлж, засвар үйлчилгээ болон хянах ажиллагааг өргөжүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж буй байгууллагуудыг бодлогоор дэмжих шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа тул бид ОХУ-ын Арзамасский приборостроительный завод имени П.И.Пландина» үйлдвэрийн бүтээгдэхүүн АРЗАМАС тоолуурыг сонгосон.



АРЗАМАС


НОӨЧИЙГ ХАМГАЛАХ БҮХ ЦОГЦ
АСУУДАЛ БА УЙЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫГ
ҮНДСЛЭЛТЭЙ ЗӨВ ТООЦОХ НЬ
УЛС ОРНЫ ХУВЬД
ХАМГИЙН ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛТОЙ
БИЛЭЭ.



ШИНЭ ТЕХНОЛОГИ: "УСНЫ АШИГЛАЛТ ХЭРЭГЛЭЭГ ТООЛУУРЖУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ" СЭДЭВТОЛОН УЛСЫН ЗӨВЛӨГӨӨН



Манай компани олон улсын зөвлөгөөний хүрээнд усны сэдвийг хөндөж "УСНЫ НӨӨЦ ДУНДАРСААР" нэвтрүүлэг бэлтгэж МҮОНТелевиз-р 2 дахь удаагаа цацлаа.



"УСНЫ АШИГЛАЛТ ХЭРЭГЛЭЭГ ТООЛУУРЖУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛУУД, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ"



Олон улсын зөвлөгөөний арга хэмжээ 2016 оны 8-р сарын 16-ний өдөр "Дэд бүтэц инженеринг" компанийн хурлын танхимд 11 цагт эхэлж зохион байгуулагчид болон зочид төлөөллүүд нийт 176 хүн хамрагдаж, зөвлөгөөний арга хэмжээг "АПЗ" Иргэний үйлдвэрлэлийн дарга Цыцулин Владислав Геннадьевич зөвлөгөөнийг албан ёсоор нээлтийг хийлгээ.



"АПЗ" ОУлсын
Маркетингийн
хэлтсийн дарга
Сурнин Михаил
Иванович

"АПЗ" Иргэний
үйлдвэрлэлийн
дарга Цыцулин
Владислав
Геннадьевич

"Дэд бүтэц
инженеринг"
компанийн
ТҮЗ-ийн дарга
Ж.Баатарсүрэн

ХСУХАТАУЗ
Зөвлөлийн
дарга
Э.Пүрэвжав.

БОАЖЯамны
ТГСГЗУАЗАлбаны
ахлах мэргэжилтэн
С.Сүхбат



Нийслэлийн Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд Ерөнхий менежер Т.Гантөмөр дарга хүлээн авч албан ёсны уулзалт хийгдлээ.

Барилга, хот байгуулалтын яамны хурлын танхимд санамж бичиг зурах ёслолын ажиллагаа хийгдлээ.



АРЗАМАС
МЭДЭЭЛЭЛЭ
ДАМЖУУЛДАГ БОЛЛОО.



БАРИЛГА,
НИЙТИЙН АЖ АХҮЙН
САЛБАРЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ
ХАНДЛАГА СЭДЭВТ
ЧУУЛГА УУЛЗАЛТ
2016.10.13

Тус чуулга уулзалтанд
"ДЭД БҮТЭЦ_УХААЛАГ
ШИЙДЭЛ" төслийн хүрээнд
"УСНЫ ХЭМНЭЛТ_УХААЛАГ
ХЭРЭГЛЭЭ" танилцууллаа.



Манай судалгааны багынхан НААУ-ний 85-н жилийн ойн ЧУУЛГА
УУЛЗАЛТ-н хүрээнд усны сэдвийг хөндөж судалгаа хийгдлээ.



Энэхүү УСНЫ НӨӨЦ ДҮНДАРСААР
судалгааг тус компанийн ТУЗ-ийн
дарга Ж.Баатарсүрэн танилцуулав.

"ДЭД БҮТЭЦ
УХААЛАГ ШИЙДЭЛ" ТӨСӨЛ



БНКУлын "Стриж телематика Азия" компанийн
Ерөнхий захирал Артем Ньюделчев А.Н.
шинэ технологи танилцууллаа.




"ДЭД БҮТЭЦ_УХААЛАГ ШИЙДЭЛ" ТУРШИЛТЫН ТӨСӨЛ АЛБАН ЁСООР ЭХЭЛЛЭЭ.



2016.12.09-ний одор: 1-р Дэл станци сууринуулалтын үйл ажиллагаа амжилттай боллоо;
а. АНТЕНН (давтамжыг тодорхойлж, тестлэлээ.) б. СТРИК (тоолуур мэдээлэл бүрэн дамжуулагдлаа.)

2016.12.30-ний одор: 2-р Суурь станци сууринуулалтын үйл ажиллагаа амжилттай боллоо;
а. АНТЕНН (давтамжыг тодорхойлж, тестлэлээ.) б. СТРИК (тоолуур мэдээлэл бүрэн дамжуулагдлаа.)



Туршилтийн төсөл нь цаашид "*Нийслэл хотын хэмжээнд ухаалац олон шийдлүүдийг хэрэгжүүлэх боломж*" чиглэлээр
мэдээлэл хийж хамтран ажилдана гэдэгт бид итгэлтэй байна.



"ДЭД БҮТЭЦ_УХААЛАГ ШИЙДЭЛ" ТӨСЛИЙН ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ ТАЛААР
ХУВИЙН АШИГЛАЛТЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН ОРОН НУТГУУДАД ТАНИЛЦУУЛЛАА.



ХУВИЙН АШИГЛАЛТ УЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД





Бид НҮБ-ын Хүүхдийн сангийнхан: Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн мэргэжилтэн Нямсүрэнгийн Батнасан



-Та өөрийнхөө талаар товч танилцууна уу?

Миний бие Архангай аймгийн Жаргалант суманд төрсөн. Би Украяны Одесса хотын Ус, цаг уурын улсын их сургуульд гидролог мэргэжил эзэмшсэн. НҮБ-ын Хүүхдийн санд орохоосоо өмнө Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Дэлхийн байгаль хамгаалах сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр зэрэгт судлаач, хөтөлбөрийн менежерээр ажиллаж байлаа.

Миний бие голын сав газрын нэгдсэн менежментийн чиглэлээр мэргэшсэн бөгөөд энэ нь усны чанар, хүртээмжийг сайжруулах НҮБ-ын Хүүхдийн сангийн ўл ажиллагаанд ихээхэн нийцэж байгаа юм. Тухайлбал, бид саяхан "Усны аюулгүй байдлын төлөвлөгөө" батлахад дэмжлэг үзүүлж, манай хөтөлбөр хэрэгжиж буй орон нутгийн хүүхдүүдийн ундны усны аюулгүй байдлыг хангахад тусласан. Энэ хүрээнд мөн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн тухай гарын авлага боловсруулж өгсөн.

-Та өөрийн ажил мэргэжлээ таван настай хүүхдэд хэрхэн тодорхойлж хэлэх вэ?

Хүүхдүүд гэртээ, сургуульдаа аюулгүй, цэвэр ус ууж, ариун цэврийг сахихад бид тусалдаг бөгөөд үүний ачаар хүүхдүүд эрүүл байж, сурлагын амжилт илүү гаргаж чадна. Мөн гарaa тогтол угааснаар өвчинеэс өөрсдийгөө хамгаалж чадах тухай эцэг эх, хүүхдүүдэд мэдлэг өгөхөд тусалдаг.

-Таны ажлын жирийн нэг өдөр яаж өнгөрдөг вэ?

Хэдийгээр өдөр бүр өөр боловч миний ажлын өдөр ихэвчлэн цахим шуудангаа шалгах, хариу бичих, баримт бичиг, тайлан боловсруулах болон мөн хөтөлбөрийн хамтрагч, түншүүдтэйгээ уулзах зэрэг ажлууд хийдэг. Заримдаа би манай төслүүдийн хэрэгжилт, явцыг хянах зорилгоор орон нутагт ажиллаж, олон нийт, иргэд болон хүүхдүүдтэй уулздаг.

-Таны ажлын хамгийн сайхан зүйл юу вэ?

НҮБ-ын Хүүхдийн сангийн тусlamжтай-гаар барьсан худаг, ариун цэврийн байгууламжийн үр дүнд хүүхдүүд цэвэр ус хэрэглэж байгааг харах нь миний хувьд хамгийн сайхан байдаг. Саяхан бид нэг том зорилгодоо хүрч чадсан. Тэр нь "Цэцэрлэг, сургууль, дотуур байрны ус, ариун цэвэр, эрүүл ахуйн норм"-ыг батлуулсан явдал юм. Энэ баримт бичгийг НҮБ-ын Хүүхдийн сан болон бусад түнш байгууллагуудтайгаа хамtran ажилласны үр дүнд баталсан. Энэ нь Монгол хүүхдүүдийн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нэхцлийг сайжруулах чиглэлээр хийсэн томоохон алхам гэж үзэж байна.

-Таны ажлын хамгийн хэцүү зүйл нь юу вэ?

Монгол Улс маш хүйтэн уур амьсгалтай, хүн ам сийрэг суурьшсан улс. Тиймээс алс хөдөө нутагт эрс тэс хүйтэн нэхцөлд худаг, ариун цэврийн байгууламж барьж босгоход зардлын хувьд хүндэрэлтэй байдаг. Гэвч хүүхэд бүр эрхээ зэдэлж, хөгжлийн боломжкоо бүрэн нээн хөгжихэд цэвэр ус, эрүүл ахуйн байгууламж чухал үүрэгтэй. Тийм болохоор тул бид үүний тулд хамгийн боломжтой арга зам, шийдлийг олохын тулд маш шаргуу ажиллаж байна.

-Таны ажлын үр дүн хүүхдийн амьдралд хэрэг болж байгааг та юнаас олж хардаг вэ?

Өнгөрсөн жил би Хөвсгөл аймгийн Баян-зүрх суманд очсон. Тухайн үед хоёр бяцхан охин сургууль дээрээ усны савнаасаа ус ууж байхыг харсан юм. Эрүүл мэндийг дэмжих болон эрүүл хүүхэд аяны хүрээнд хүүхэд бүр өдөрт наад зах нь нэг литр ус ууж байх ёстой гэдэг нөлөөллийн ажил зохион байгуулсан юм. Ингээд сургуулийн удирдлагын хүчин чармайлтын үр дүнд хүүхдүүд цэвэр ус уухыг байнгын хэвшил болсон байхыг хараад маш их баярласан шүү.

-Чөлөөт цагаа та хэрхэн өнгөрүүлдэг вэ?

Би хүүхэд байхдаа өвлүүн цагт найз нэхөдтэйгээ сумын ойролцоо гол дээр очиж, тэшүүрээр гулгаж, хоккей тоглодог байлаа. Тиймээс би өвлүүн спортоод дуртай болж өссөн. Одоо хүртэл би чөлөөт цагаараа цанаар гулгах дуртай.

-Таньтай ижил төстэй ажил хайж байгаа хүмүүст та ямар зөвлөгөө өгөх вэ?

Аливаа зүйлд тууштай хандах нь хамгийн чухал. Усны салбар өөрөө ажиллахад хүнд хэцүү нэхцөлтэй. Тиймээс заримдаа шантрах үе байж болно. Гэхдээ хүндийг давж чадсанаар олон улсын байгууллагад ажиллахад шаардлагатай туршлага хуримтлуулна гэсэн уг. Тэгэхээр миний өгөх зөвлөгөө бол "Битгий бууж өг!".



МОНГОЛ УЛСЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАВЬЯАТ АЖИЛТАН С.СҮХЭЭ: Цаг заваар хомсхон ч болгоё гэсэн сэтгэл, зүтгэл, итгэл З байваас бүтэхгүй амжихгүй юм байхгүй гэж бодоцгоо.



-Юуны өмнө танд Монгол улсын Үйлчилгээний Гавьяат Ажилтан цол тэмдгээр шагнадсанд баяр хүргэе. “Үйлчилгээний гавьяат ажилтан” энэ шагнал хүйтэнд хөрж, халуунд халж, ажлаа хар бор гэж гололгүй чин сэтгэлээсээ хичээж хөдөлмөрлөсний тань үр шим байх. “Үйлчилгээний гавьяат ажилтан” цол тэмдгээр шагнагдах үеийн сэтгэгдлээ хуваалцахгүй ю?

Баярлалаа. Энэ бол надтай хамт үе үед хамт ажиллаж байсан хамт олон, одоо ажиллаж байгаа хамт олон, гэр бүлийн маань хамтын зүтгэлийг төр засаг маань үнэлсэн үнэлгээ юм.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар бол нэрнээсээ эхлээд нийт ард түмний нийтлэг эрх ашгийн төлөө төрөөс түмэн олондоо үзүүлж буй цогц үйлчилгээ бөгөөд үе үеийн ахмадууд, мэргэжилтэн инженер техникийн ажилтан, ажилчдын нэр их хөдөлмөрийн үр шимээр өнөөдрийг хүрсэн.

Манай салбар оршин суугч иргэд, байгууллагуудад ундны цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж цэвэрлэх, халаалт, цахилгаанаар хангах, хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах тэдгээрийн инженерийн байгууламж, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган, иргэдэд хамгийн ойр нэн шаардлагатай хариуцлагатай үйлчилгээг үзүүлж, ард иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэн төрийн үчилгээг 24 цагийн турш тасралтгүй хүргэдэг онцлогтой салбар юм.

Энэхүү хариуцлагатай ажилд 40 жил зүтгэж ирснийг минь үнэллээ.

Улс орны олон салбарт ажиллаж байсан, ажиллаж байгаа хамгийн тэргүүний хүмүүст төрийн дээд шагнал гардуулсанд баяртай байна.

-Та сурч байсан сургууль, эзэмшсэн мэргэжлил, ажил хөдөлмөрийн гараагаа хаанаас эхэлж байсан, НААУ-ний салбартай амьдралаа хэрхэн холбосон талаар сонирхуулаач.

Миний үндсэн мэргэжил химич. МУИС-г төгсөөд Улсын барилгын зөвлөлийн БЗИ-ийн барилгын материалын лабораторийг анх байгуулан эрхлэгчээр нь томилогдож хөдөлмөрийн гараагаа эхэлсэн юм. Дараа нь Толгойтын тоосгоны нэгдсэн заводаас эхлээд барилгын салбарт ажиллаж байлаа.

Ингээд 1978 оноос ОСНАА-н салбарт ирж 1.3.7.6-р конторыг удирдан 1999 он хүртэл ажиллаад улмаар компани байгуулан хувийн хэвшилд ажиллах болсон. Насаараа л би хүнтэй ажиллаж хүмүүсийг зохион байгуулах, удирдах, уриалан дуудах алба ажлыг л хийж явна даа.

Улс орны эдийн засаг зах зээлийн тогтолцоонд шилжих үед төр засгаас хувийн хэвшлийг дэмжих бодлого явуулсанд зориг шулуудан компани байгуулахаар шийдсэн. Миний хувьд уг салбарт олон жил ажилласан туршлага, мэдлэг хуримтлуулсан байсан нь нелөөлсөн гэж хэлж болно. Ингээд “Тангар инвест” компанийнхантай санал солилцон хамтран ажиллахаар болж тэдний барьж ашиглалтанд өгсөн 5-р хорооллын 3-а байрны ашиглалт үйлчилгээг хариуцан авсан.

Цаашид тус компани 13-р хороололд 1000 айлын орон сууц барьж эхэлснээр бид энд төвлөрч өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж өргөжин тэлснээр манай компани 16 жил болж байна.



-НААУ-ний салбарт тасралтгүй 40 жил ажилласан танд олон сайхан дурсамж, байгаа байх. Онцолж дурьдвал.....

Миний бие Нийтийн аж ахуйн үйлчилгээ-ний салбарт 40 жил ажилласан нь материаллаг үйлдвэрлэлийн салбараас материаллаг бус салбарт ажилласан нь их онцлогтой.

Хүнтэй ажиллах, хөдөлмөрийн хамт олныг зохион байгуулах, удирдах, уриалах, хүмүүжүүлэх ажлаас иргэд суугчидтай тулж ажиллах, амьдрах тав тухыг хангах өргөн цар хүрээтэй албандаа шилжин хийж явна даа.



-Та ямар үед ажлаараа хамгийн их баахархдаг вэ?

Миний бие нийслэл хотын суугчид, иргэдтэй нүүр тулан дулаан, халуун хүйтэн ус, цахилгаанаар тасралтгүй хангаж гомдолгүй байлгах зорилгоо хангах үүрэг хүлээсэндээ баярлаж, баахархаж явдаг даа.

-Та энэ олон жил ажиллахдаа ажлаасаа халширч шантарч байв уу. Тэр л ажил миний хамаг тэвчээр, чадлыг шавхсан даа гэж бодогдох юм уу?

Энэ олон жил Нийтийн аж ахуйн үйлчилгээний бүх салбарт ажиллахдаа шантрах, халшрах, тэвчээр алдах үе байдаг боловч хүлээсэн үүрэг гэж бодохоор цаг ямагт даван туулах л гэсэн чин сэтгэлтэй зорилго тавьдаг, хамт олноо ч тэр зүгт чиглүүлдэг.

Бэрхшээл их байна аа. Гэхдээ бэрхшээл гэдэг хоёр талтай л даа. Өөрийн үйл ажиллагаанаас шалтгаалахын зэрэгцээ бусдын хараат байдлаас үүдсэн бэрхшээл хэцүү. Цахилгаан тасарлаа, ус тасарлаа, байр хүйтэн байна, яах вэ? Сүхээ даргаа гээд л утасдана шүү дээ. Энэ бүхнийг тоочих хэрэггүй гэж бодож байна. Хүн хүндээ тавих анхаарал халамж, хүний төлөө гэсэн сэтгэл зүтгэл, салбарын хөгжил дэвшлээр яваандаа арилах зүйл.

-Та гэр бүлийнхнийхээ тухай яриач. Таны ажил хөдөлмөрийг гэрийнхэн тань хэр сайн ойлгодог вэ?

Ажилласан 55 жил бол цаггүй ажил гэдгийг гэр бүл минь ойлгодог. Эхнэр минь их сургуулийг төгсөөд УБДСургуулийн номын сангийн эрхлэгчээр 30 гаруй жил ажиллаад насандаа суусан. Би Ганбат, Ганзориг, Гантөмөр, Гантулга гэсэн дөрвөн хүүтэй. Гурав нь эцгийнхээ ажил мэргэжлийг өвлөн орон сууц нийтийн аж ахуйн салбарт ажиллаж байгаа.



-Салбарыхан таныг энэ системд тасралт-гүй 40 жил үр бүтээлтэй, эрч хүчтэй ажилласнаар тань илуутэй мэддэг. Таны энэ их эрч хүч, ажлын арга барилын нууц юунд оршиж байна.

Нийт 55 жил үүнээс Орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт 40 жил ажилласны эцсийн үр дүн бол миний хамт олон, тэдний итгэл зүтгэл, эв нэгдэл, хөдөлмөрт хандах хандлага, удирдлага, зохион байгуулж байсан нь миний эрч хүч, ажлын үр дүнгийн нууц нь юм болов уу.

-Сүхээ дарга та эрч хүчтэй, залуу сэтгэлгээтэй, цоглог хүн юмаа. Таны хобби юу вэ?

Баярлалаа. Би бол их өөдрөг үзэлтэй хүн шүү дээ. Хүний насыг бол энэ чинь тоо л гэж боддог. Би өглөө бүр 5 цагт босоод дасчихсан. Энэ их чухал.

Хүн ажилдаа дуртай явж гэрлүүгээ яaran очдог бол аз жаргалтай гэсэн мэргэдийн үг байдаг аа. Энэ үнэхээр тийм шүү. Цаг заваар хомсхон байдаг ч гэсэн болгоё гэсэн сэтгэл,



Өнөөдөр танд цоглог эрч хүчтэй нэгэн харагдаж байгаа бол миний хоббины ач тус гэж бодож байна. Миний өөрийн нөлөө ч байдаг байх. Манай хамт олон спорт урлагийн хамтлаг байгуулж хот, дүүрэг, салбараас зохиож байгаа арга хэмжээнүүдэд тогтмол идэвхитэй оролцож ирснээр манай байгууллагыг нийтийн аж ахуйн хамт олон маань мэдэж байгаа байх аа.

Мөн найз нөхөдтэйгээ уулзаж санал сэтгэгдлээ хуваалцах, хөгжилтэй хөөртэй байх шиг сайхан юм хаана байхав дээ. Тэд нартайгаа хүртэл зав чөлөөгөөрөө тоглож, наадаж, аялж, зугаалж амарч байдаг шүү.

Аливаа хүнд байгууллагын, салбарын шагнал, хамт олны хүндлэл их урам дэм өгдөг. Харин та төрийн дээд шагнал “Гавьяат” цолыг хэр их хичээл зүтгэлээр хүртлээ гэж бодож байна?

Тоосгоны заводад ажиллахдаа байгууллага маань яамандаа 8 удаа, улсад 3 удаа тэргүүлж Алтан гадас одонгоор шагнагдсан. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарт ч муугүй ажиллаж байна. Үйлчилгээний гавьяат ажилтан болсон нь Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын ажилтны шагнал, миний оролцоо.



-Үүгээр ярилцлагаа өндөрлөө. Өөрийн ажлын арга барил, үзэл бодлоо хуваалцсан танд баярлалаа.

Та бүхэндээ мөн баярлалаа. Нийт салбарт ажиллаж байсан ахмадууд болон одоо ажиллаж байгаа мэргэжил нэгт хүмүүс хамт олондоо эрүүл энх, ажлын амжилтыг хүсэн ерөөе.



АВТОХУДАГ

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БАГЦ

- ✓ Удирдлагын тохооромж
- ✓ Цахилгаан самбар
- ✓ Удирдлагын иж бүрэн компьютер
- ✓ Түгээх тохооромж
- ✓ Дотор цахилгааны болон усны сантехникийн монтаж шинээр угсарна
- ✓ Хяналтын камер, бичигч
- ✓ Гадна гэрэлтүүлэг
- ✓ 300 ш карт

ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Цахилгаан эх үүсвэрт холбогдсон байх.
- Гүний болон зөөврийн, төвийн шугамын аль эх үүсвэрээс уснаа хангадаг байж болно.



ХЭРЭГЛЭГЧ

1. Карт уншуулах
2. Мэдээлэл
3. Зөвшөөрөл өгөх
4. Зарцуулалт
5. Хүсэлт илгээнэ
6. Ус түгээнэ



ТӨХӨӨРӨМЖ



АВТОМАТ УДИРДЛАГЫН СИСТЕМ

Баталгаат хугацаа 1 жил

Картын цэнэглэтийн тайлан, усны зарцуулалтын тайлан, хэрэглэгчийн тайлан гаргана.

Интернетэд холбогдож худгийн мэдээг суманд аймагт нэгтгэж гаргах боломжтой.

Усны зарцуулалт буюу 1литр усыг шаах хурд нь 2.26 секунд

Баталгаат хугацаанд үйлдвэрлэлийн болон угсралтын буруугаас шалтгаалсан гэмтлийг үнэ төлбөргүй засварлана.

АРЗАМАС Стриж

«АРЗАМАС»
МЭДЭЭЛЛЭЭ ДАМЖУУЛДАГ БОЛЛОО.

ЯАГАД «АРЗАМАС»-СТРИЖ-Г СОНГОХ БОЛОВ.
МАНАЙ КОМПАНИИ ХЭРЭГЛЭГЧ АЖ АХҮЙ НЭГЖ БАНГУУЛАГАА, АЙЛ ӨРХИЙН
ШААРДЛАГЫГ ХАНГАСАН ХАМГИЙН ЧАНАРТАЙ, ХАМГИЙН НАЙДВАРТАЙ УНДЫН УСНЫ
ТООЛУУР НИЙЛУУЛЖ, ШИНЭ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИЙН НИЙТИЙН АЖ АХҮЙН
ҮЙЛЧИЛГЭЭНД НЭВТРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЮМ.



ОИЦЛОГ ДАВУУ ТАЛУУД:

Ашиглалт үйлчилгээний байгууллагад:

- ✓ Ажилчид сар болгон аж ахуй нэгж, айл өрхийн тоолуур бүрний заалтыг орж авах, утсаар оршин суугчдаас мэдүүлжихийн шаардах, таах, буруу бичих, шинвилт хийдээз алдаа гаргах гах мэт оршин суугч ашиглалтын байгууллагын хоорондын үл ойгогцон үтүү болдог.
- ✓ Олон хүний гараар шат дамжуултайгаар хийх хөдөлмөрийн багасгах, ажиллах хүчиний хэмзээ.
- ✓ Ашиглалт үйлчилгээний байгууллага нь өрөнхий тоолур дээр сурвалжадсан тохиолдоод оршин суугчид усны хэрэгзээг хийнж харьцуулалт хийх, дүгнэлт гаргах, сар болгоны бичилтийн санхүүгийн программуу шуд шилжүүлэх, мон ямар ч системүүдээз нэлтийн боломжтой.
- ✓ Харьяланлагдах орон сууцинаахаа айл орх тус бурин тооулурын заалтыг мэдээллийн системээс харах, усны алдагдлыг илрүүлэх, бүрэн хянах боломжтой.
- ✓ Оршин суугч иргэд хэрэглэсэн усныхаа үнинг төлно.



ОХУ-ЫН, БНКАЗАХСТАН УЛССУУДАД Стриж СИСТЕМИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЕН



Office хаяг: УБ хот, СБД, 8-р хороо, Оюутны гудамж-33, Танан төв 301
Захиргаа: 7595-9090, 9009-3636

Борлуулалтын алба: 8055-3636, 8044-3636

ДЭД БҮТЭЦ Инженеринг ХХК

<https://www.dbi.mn>

АРЗАМАС

ЕВРОП ТЕХНОЛОГИ
ЧАНАРЫН БАТАЛГАА

ОХУ-ЫН «АРЗАМАССКИЙ ПРИБОРОСТРОЙТЕЛЬНЫЙ ЗАВОД ИМЕНИ П.И.ПЛАНДИНА»
ҮЙЛДВЭРТ ҮЙЛДВЭРЛЭГДСЭН «АРЗАМАС» ТООЛУУР НЬ
БАКТЕР УСТАХАШ ШИНЖ ЧАНАРТАЙ ХАЛУУН, ХҮЙТЭН УСНЫ
УНИВЕРСАЛ ТООЛУУРЫГ ОРИШН СУУТЧ, ХЭРЭГЛЭГЧИД
ТА БУХЭНД САНАЛ БОЛГОЖ БАЙНА.

ОИЦЛОГ ДАВУУ ТАЛУУД:

- 
 - ✓ БУТЦЭД НЬ НИНГИЯН ЭСРЭГ ҮЙЛЧЛУУДЫГ НЭМЭЛҮҮДТҮҮД ДАЛАВЧИЙГ ХЭРЭГЛЭСЭН, ДАЛАВЧИЙГ ЭРГЭХД МУНГОНДОННОР ХАНАДАГ.
 - ✓ ТООЛУУРЫН БУХ ЭД АНГИ НЬ АЛЗ "ҮЙЛДВЭРЛЭГДСЭН";
 - ✓ ТООЛУУРЫН НЬ ГҮҮЛНН ХИЙДТЭЙ ТУД ЭДЭЭГЭЭ УРТ;
 - ✓ АШИГЛАЛТЫН ХУГАЦАА ТАСРАЛТУУ 12 ЖИЛ;
 - ✓ ТООЛУУРЫН ЭЭЛЖЛЭЭ НЬ УСНЫ ГЭЭНТЭНДИЙН ДАРАЛТЫГ ТЭСВЭРЛЭНЭ;
 - ✓ ДАРАЛТЫН АЛДАГДАГ БАГАТАА;
 - ✓ УЧРАЛТАНД БОСОО БОЛОН ХЭВТЭЭ БАЙРЛАЛДАХ СУУРИЛУУЛАХ БОЛОМЖТОЙ;
 - ✓ ХАЛУУН ХҮЙТЭН УСНЫ ШУГАМАДАА АЛЗ ТОХИРОХ БОЛОМЖТОЙН УНИВЕРСАЛ ТООЛУУР;
 - ✓ ШИНЭЛЭГ БҮТЭЭГДХҮҮН НЬ ҮЙЛДВЭРЛЭЛ ВА АШИГЛАЛТЫН ҮЕД ХУРИМТЛАГДСАН ТУРШАЛЫН ҮНДСЭН ДЭЭР ЗОХИОН БҮТЭЭГДСЭН БОГОДДОО ТООЛХООН МЕХАНИЗМЫН САЛЖИРУУЛСАН ХУВИЙБААР ТОНГОЛОГДСОН.
 - ✓ МОНГОЛЫН НӨХЦӨЛДОО ТОХИРУУЛАГДСАН ПАСПОРТЫН ОРУУГАА, ЗАСЛААХ ХОФОНДЫН ХУГАЦАА БАТАЛАГДАХ ХУГАЦАА УРТАСГАДСАН (6 ЖИЛ).

АРЗАМАССКИЙ ПРИБОРОСТРОЙТЕЛЬНЫЙ ЗАВОД ИМЕНИ П.И.ПЛАНДИНА ҮЙЛДВЭР НЬ 1957 ОНД АРЗАМАССЫН БАГАЧАД ҮЙЛДВЭРНЭЙ НӨГДЛХИЙН ЭРТЭНЭЭР БАЙГУУЛАГДСАН. ОЛОХ ЦЭРТНҮҮЛСНЭЙН НӨГДЛХИЙН 2 ГАЗААРЫН 21 ХУВЬ ОХУ-ЫН ТОРННЫН МЭДЭЭЛЛЭНД БАГАДАГ. БАЙГУУЛАГДЫН БОЛОН ОУЛЫН ISO 9001:2010, ISO/IEC 17025:2007 СТАНДАРТЫН ШААРДЛАГДАГ НӨХЦӨЛНҮҮЛГЭНДИЙН БҮТЭЭГДХҮҮНД, МОНГОЛ УЛС, ДЭД БҮТЭЦ Инженеринг компанийн зорилтууд ҮЙЛДВЭРТЭВ.

ОНОДОР ОЛОН УСНЫ ХЭМЖЭЭД АШИГЛАГДАХ БҮЙ ШИНХ ТЕХНИК ТЕХНОЛОГИИХООРЫН НӨХЦӨЛНҮҮЛГЭНДИЙН БАСКАР УЧИЛГЭЭНД БОЛОН ХИНАА АЖИЛГАЛААД ОРГОЖУУЛХАА, ЭЗИСЧИЛЭЭД УЛТ АЛЖИЛАГАА ЭРХИЙН БҮЙ БАЙГУУЛАГДЫГ БОЛГАХОГООД ДЭРЖИНХ ШААРДЛАГАА ЗҮЙНЭССОР ТАВИДААН БАЙГАА ТУДЫН ОХУ-ЫН АРЗАМАССКИЙ ПРИБОРОСТРОЙТЕЛЬНЫЙ ЗАВОД ИМЕНИ П.И.ПЛАНДИНА ҮЙЛДВЭРНЭЙН БҮТЭЭГДХҮҮН НЬ АРЗАМАС ТООЛУУРЫГ СОНГОГСОН ЮМ.



ХСХХАТАУАЗ-ийн 2016 оны 94 дугаар тогтолцоо.

2017.01.01-дээрээс мөрдөгдөх эхийн болно.

4 ам бүтцийн усны тооптуулж, тооптуулж хэрэгжүүлж, тооптуулж харьцуулж үзүүлж.

Тооптуулж айл өрх/ам бүт:

Төлбөрийн нэр	Ам бүт	Нэгж өрх /ter/	Сард төлөх /ter/	Жилд /ter/
Цэвэр усанд	4	5,280	21,120	253,440
Бохир усанд	4	3,300	13,200	158,400
Нийт		34,320.00	411,840.00	

Дээрх тооцоогоор усны тооптуулж өрхөөс сард 21,568.8 төгрөг, жилд 258,825.6 төгрөг шөвр, бохир усны төлбөрт илүү төлж байна.

Тооптуулж айл өрх/ам бүт:

Төлбөрийн нэр	Ам бүт	Нэгж өрх /ter/	Сард төлөх /ter/	Жилд /ter/
Цэвэр усанд	12.6 м ³	605	7,623	91,476
Бохир усанд	12.6 м ³	407	5,128.2	61,538
Нийт		12,751.20	153,014.40	

Сард илүү төлдөгдэж байсан 21,568.8 төгрөгийн усны тооптуулж 1 килинг хугацаанд 2 ухлагад тооптуулж үнчийн төлж дүссэнээр цаашаа болиж хэрэглэгээд усны төлбөрт төлж боломжтой болж байна.

4 АМ БҮЛТ ӨРХ ҮНЧИЙН ХИЙСЭР ХЭМНЭХ БОЛОМЖ

Сард / ter/	Ам бүт / ter/	Дараа нь / ter/	ХЭМНЭЛТ / ter/
Сард / ter/	Жилд / ter/	Сард / ter/	Жилд / ter/
Цэвэр усанд	21120	253440	7623
Бохир усанд	13200	158400	5128.2
Нийт	34320	411840	12751.2

153014.4 21568.8 258024.4



Office хаяг: УБ хот, СБД, 8-р хороо, Оюутны гудамж-33, Танан төв 301

Захиргаа: 7595-9090, 9009-3636

Борлуулалтын алба: 8055-3636, 8044-3636

ДЭД БҮТЭЦ Инженеринг ХХК

<https://www.dbi.mn>